ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НУТАГ ДАХЬ ГАЦУУРТЫН ОРД, ТҮҮНИЙ ОРЧНЫ БҮСЭД ХИЙСЭН УГСААТНЫ ЗҮЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

I ХЭСЭГ

УЛААНБААТАР
2015

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НУТАГ ДАХЬ ГАЦУУРТЫН ОРД, ТҮҮНИЙ ОРЧНЫ БҮСЭД ХИЙСЭН УГСААТНЫ ЗҮЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Төслийн гүйцэтгэгч: С.ЧУЛУУН – Доктор (Ph), дэд проф, ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн захирал

Б.БАДМА-ОЮУ – доктор (Ph.D), Археологи, угсаатны зүйн авран хамгаалах салбарын эрдэм шинжилгээний ажилтан

Г.БЯМБАРАГЧАА – магистр, Нийгэм соёлын хүн судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан

М.АЛТАНШАГАЙ –магистрант, Археологи, угсаатны зүйн авран хамгаалах салбарын эрдэм шинжилгээний туслах ажилтан

Захиалагч байгууллага: SUSTAINABILITY

Тайлан өмчлөгч: ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. Улаанбаатар-51, Жуков-77 ШУА-ийн Нэгдсэн I байр
Утас: 452894, факс 452899

УЛААНБААТАР
2015

ГАРЧИГ

ТАЛАРХАЛ 6
ХУРААНГУЙ ТАЙЛАН: 7
Судалгааны нэр 7
Хамрах хүрээ 7
Судалгааны баг 7
Хээрийн судалгааны ажлын гол зорилго 7
Талбайн сонголт 7
БАЙРШЛЫН ТОДОРХОЙЛОЛТ: 10
СОЁЛЫН ӨВД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, УЧИРЧ БОЛЗОШГҮЙ АЮУЛ: 10
ХЭЭРИЙН СУДАЛГАА ХИЙСЭН ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ: 11
Хугацаа: 11
Багийн бүрэлдэхүүн 11
Судалгаанд хамрагдсан иргэдийн тухай: 11
Ярилцлага авсан нутгийн захиргааны төлөөлөл 11
Хээрийн судалгааны нөхцөл байдал 12
Судалгааны арга зүй 12
МОНГОЛЫН УГСААТНЫ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 18
НЭГ. СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НИЙГМИЙН БАЙДАЛ 24
Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж 29
Хүн амын тоо бүртгэл 29
Шилжилт хөдөлгөөн 32
Хүн амын хөдөлмөр эрхлэлт, дундаж цалин 32
Ажиллагсдын тоо 33
Өрхийн орлого, зарлага 34
Боловсрол 34
Ерөнхий боловсролын сургуулиуд 34
Политехникийн коллеж 34
ХӨДӨӨ АЖ АХУЙ 35
Мал аж ахуй 35
Газар тариалан, хүнсний ногоо 35
Ургац хураалт 36
ХОЁР. УГСААТНЫ ЗҮЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН 37
АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ 37
УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ УХААН 38

Бэлчээр ашиглах уламжлал....38
Хурдан морины соёл....39
Уламжлалт эм эмчилгээний мэдлэг ухаан....40
Ан гөрөөний мэдлэг ухаан....40
Уламжлалт шүтлэг бишрэл, хорио цээр....41
ГУРАВ. НУТАГ ОРОН, ТҮҮХТ ХҮМҮҮСИЙН ТАЛААРХ АМАН ТҮҮХҮҮД....44
Баатар бэйлийн тухай....44
Естийн рашаан нээсэн тухай....45
Түгж жанжин....46
Ширхэнцэг уул....48
Хэрх уул....48
Хараагийн Ноён уул....49
Мичин модны гарам....49
Зараа толгой....49
Хараа гол....50
Хоёр Мандал уул....50
Баянсуудал уул....50
Хүүш Дашдаваа....51
Ажнайн даваа....51
Буу толгой....52
Царамт....53
Гурван баян....53
Хятад иргэдтэй холбоотой аман түүх....54
Оорцог....55
Сүхбаатарын хөшөө....57
ДӨРӨВ. УУЛ УУРХАЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛЭМЖ....59
ТАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ....60

ХҮСНЭГТ

Хүснэгт 1 Судалгааны багийн гишүүд....11
Хүснэгт 2 Ноён уулын хойд амны иргэд....13
Хүснэгт 3 Ноён уулын амны иргэд....15
Хүснэгт 4 Ноён уулын зүүн урд үзүүр, Мандал 5-р баг, Түнхэл тосгоны иргэд....16
Хүснэгт 5 ”Бороо Гоулд” уурхайн орчмын иргэд....17
Хүснэгт 6 Мандал сумын үндэстэн ястны байдал \2010 оны байдлаар....26

Хүснэгт 7 Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5-р баг, Түнхэл тосгоны үндэстэн ястны байдал.....27
Хүснэгт 8 Сэлэнгэ аймгийн Мандал сумын 4-р баг, Хэрх тосгоны үндэстэн ястны байдал.....28
Хүснэгт 9 Мандал сумын газар ашиглалт 29
Хүснэгт 10 Мандал сумын хүн ам, багаар 30
Хүснэгт 11 Сумын өрхийн тоо, багаар 31
Хүснэгт 12 Мандал сумын хөдөлмөр эрхлэлт.....33
Хүснэгт 13 Ажиллагсдын тоо 33
Хүснэгт 14 Нийт суралцагчид, мэргэжлээр 35
Хүснэгт 15 Үр тариа, хүнсний ногооны ургац 36

ЗУРАГ

Зураг 1 Гацууртын уурхайн талбай, нийтийн хэрэглээний замын эргэн тойрны соёлын өв бүхий газрууд.....9
Зураг 2 Мандал сумын хүн амын насны хуваарилалт.....30
Зураг 3 Сумын хүн ам, оршин суух байршлаар 31
Зураг 4 Сумын өрх, оршин суух байршлаар 32
Зураг 5 Мандал сумын өрхийн тоо, 2004 - 2014.....32
Зураг 6 Мандал сумын шилжин ирсэн, шилжин явсан хүмүүсийн тоо, 2011 - 2014 32
Зураг 7 Малчин Даваасүрэн.....38
Зураг 8 Ноён уулын дээд овоо, Хаан оргил 42

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг амжилттай хэрэгжүүлэхэд гол нөлөө үзүүлсэн “Sustainability”-ийн зөвлөх Б.Баярмаа, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт угсаатны зүйн судалгаа хийх явцад бидний ажлын зорилгыг ойлгож туслалцаа үзүүлсэн Хэрх 4-р багийн засаг дарга А.Дашзэвэг, Мандал-5, Түнхэл тосгоны засаг дарга С.Раднаабазар, Хэрх багийн өндөр настан, түүх сонирхогч судлагч Б.Цэнд-Очир, Хэрх тосгоны соёлын төвийн дарга П.Сайнтуяа, Дотоод ажилтан Б.Отгончимэг, Түнхэл 5-р багийн соёлын төвийн дарга Ц.Байгалмаа, Түнхэл тосгоны захирагчийн албаны ажилтан н.Ариунгэрэл нар болон хээрийн судалгааны хугацаанд мэдээлэл өгч бидний судалгааны ажлын үр дүнд голлох үүргийг хүлээсэн орон нутгийн иргэд, малчдад гүн талархал илэрхийлж байна.

ХУРААНГУЙ ТАЙЛАН:

Судалгааны нэр: Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дахь Гацууртын орд, түүний орчны бүсэд угсаатны зүйн хээрийн тандалт судалгаа хийж, орон нутгийн иргэд, малчид, удирдах байгууллагын ажилчидтай уулзаж, ярилцлага хийн, холбогдох мэдээ баримт, статистик мэдээ, эх сурвалжуудыг авсан.

Хамрах хүрээ: Хээрийн судалгааны ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг, Ноён уулын орчим, түүний хойд ам болох Хөх Билүүтэйн амын Хэрх 4-р баг, Ноён уулын зүүн урд ам болох Балжийн ам, Мандал 5-р багийн бүс нутгуудаар явж судалгааны материал цуглууллаа.

Судалгааны баг: ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Археологи-Угсаатны зүйн авран хамгаалах салбар, Угсаатны судалгааны салбарын судлаачдын хамтарсан 3-н гишүүн, жолооч гэсэн 4-н гишүүнээс бүрдсэн баг Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг, Ноён уулын орчмын малчин өрх айлууд болон сумын төвийн зарим айлуудаар явж судалгаа хийлээ.

Хээрийн судалгааны ажлын гол зорилго нь тус бүс нутагт амьдарч буй малчид, иргэдийн амьдралын орчин нөхцөл, уламжлалт аж ахуй эрхлэлт, уул уурхайн үйл ажиллагаа болоод уламжлалт амьдралын харилцаа, түүний өнөөгийн байдал, орон нутгийн иргэдийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд өгч буй үнэлэмж, ач холбогдол, орон нутгийн иргэд, малчдын дунд тархсан аман түүх, мэдлэг ухааны уламжлал зэрэг асуудлуудын талаар тодруулах явдал байлаа. Судалгааны ажлын хүрээнд Ноён уулын ар, өвөр амууд болох Билүүтэй, Балжийн ам дагуу нутаглаж буй нутгийн малчин айлуудаар явж, сум, орон нутгийн удирдлагуудын төлөөлөл, сумын төвийн зарим айлуудаас төлөөлөл болгон хэд хэдэн айлуудаар явж судалгааны эх хэрэглэгдэхүүн, материалуудаа цуглууллаа. Судалгаанд нийт 50 гаруй иргэд оролцсон бөгөөд Хэрх-4 багийн 20 айл, Мандал-5, Түнхэл тосгоны 15 айл, Бороо гол орчмын 7 айлын нийт 55 хүн хамрагдсан бөгөөд үүнээс нутгийн уугуул айл - 9, Завхан аймгаас - 3, Дундговь аймгаас - 2, Ховд аймгаас - 7, Архангай аймгаас - 3, Увс аймгаас - 4, Баян-Өлгий аймгаас - 2, Баянхонгор аймгаас - 3, Хөвсгөл аймгаас – 4, Говь-Алтай аймгаас – 3 буюу нийт 10 аймгийн 31 сумын гаралтай иргэд хамарсан болно. Насны хувьд 31 – 80 насны 28 эр, 14 эм, дунджаар 50-55 насны иргэдтэй уулзаж ярилцлага авчээ. Яс үндсийн хувьд халхын боржигин, олхунуд, харчин, шарнууд зэрэг овгийн иргэд дийлэнх байсан ба энэ нь тус аймаг хуучин Түшээт хан аймгийн харъяа буюу үндсэн хүн ам халх байсантай холбоотой юм. Бусад угсаатны бүлгийн хувьд торгууд – 1, баядын харагчууд, тайжууд овгоос тус тус – 1, тувагийн соён овог – 2, казахын жадык овог -2, хотонгийн шаавай элхэн – 2, ойрадын хойд овог- 2, монгол урианхан -1 хүн бүртгэсэн.

Талбайн сонголт: Бидний хийсэн хээрийн судалгааны үндсэн бүс нутаг нь Ноён уулын орчмыг хамарсан бөгөөд түүнээс хааш хааш 20 орчим км зайд судалгааны үндсэн бүсээ тогтоосон. Энэ нь тухайн орчинд байгаа малчдын нутаглаж байгаа байршил болоод судалгааны үндсэн зорилго зэргээс хамааран тогтоосон бүс болно. Бидний хийсэн хээрийн судалгааны ажлын үр дүнгээс харахад тус бүс нутагт бусад аймаг сумууд, тэр дундаа баруун зүгийн аймгуудаас хүмүүс нүүдэллэн ирж суурьшин амьдрах нь олонтаа тохиолдох бөгөөд тэр хирээр уугуул хүн амын тооны харьцаа улам бүр багасч байгаа нь ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд гаднаас шилжиж

ирэгсдийн тоо их байхын хирээр орон нутгийн уугуул иргэдийн амьдралын орчин, түүхэн соёлын уламжлалт мэдлэг ухаан, түүнд холбогдох аман түүхийн мэдлэг бага ажиглагдаж байна. Харин тус бүс нутагт гадны сум, аймгуудаас ирээд олон жилийн туршид амьдарч буй иргэдийн хувьд энэ байдал харьцангуй бага буюу XX зууны дунд үед амьдарч байсан нутгийн уугуул иргэдээс сонсож, мэдсэн түүхэн мэдлэг ухааныг өнөө үед тодорхой хэмжээгээр тээж ирсэн нь бидний судалгааны явцад анзаарагдаж байлаа.

Хээрийн судалгааны гол үр дүн нь холбогдох асуудлын талаарх нутгийн уугуул иргэд, малчдын зүгээс өгч байгаа мэдээлэл, тайлбар болох бөгөөд түүнд нутгийн уугуул иргэдийн зүгээс өгч байгаа ач холбогдол үнэ цэнэ болох юм. Бидний хийсэн хээрийн судалгааны материалын үр дүнгээс харахад тус бүс нутагт эртнээс нааш тахиж, шүтсээр өдгөөг хүрсэн багагүй уул овоод байсаар байна. Тэдний дунд хамгийн том байр эзэлдэг уул хайрхан бол Ноён уул юм. Түүний тахилгыг социализмын үед хэсэг хугацаанд завсарлаж байгаад 1990-ээд оны эхэн үеэс эхэлж дахин сэргэсэн байна. Сүүлийн жилүүдэд Ноён уулын тахилгын зан үйлд тодорхой хэмжээгээр өөрчлөлт орж байгаа нэгэн томоохон жишээ нь тахилгыг бөөгийн зан үйлээр хийж байгаа явдал болж байна. Үүнийг нутгийн иргэд тийм ч таатай байдлаар хүлээж авахгүй байгаа нь бидний хээрийн судалгааны явцад ажиглагдаж байна. Хуучин үедээ Ноён уулыг урд талаас нь буюу Балжийн ам байгаа талаас нь гарч тахидаг байсан бол сүүлийн жилүүдэд хойд талаас нь гарч тахидаг болсон гэнэ. Үүний учир нь уулын урд хормойд уурхайн түр байрлах байрууд (Campus) баригдаж, түүнийг тойруулан төмөр тороор хашаа барьж түүгээр компаний ажилчдаас бусад хүмүүсийг явуулахгүй болгосонтой холбоотой юм.

Хээрийн судалгаа хийсэн бүс нутаг нь газарзүйн шинж чанарын хувьд газар тариаланг эртнээс нааш эрхэлж ирсэн бөгөөд энэ хирээр өнөөдрийн байдлаар багагүй хэмжээний газрыг тариалангийн талбай болгосон байна. Тариалангийн талбай багагүй хэмжээний газрыг эзэлдэг учраас малын бэлчээрийн хүрэлцээ нэлээд багасч байгаа ажээ. Энэ сумд баруун талын аймгуудаас нүүж ирэх малчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа бөгөөд тэр хирээр малын тоо толгой тогтмол нэмэгдэж байна. Тиймээс газар тариалан, нүүдлийн мал аж ахуй эрхлэлт гэсэн хоёр томоохон хэв маяг энэ бүс нутагт зөрчилдөх хэмжээнд хүрч эхэлжээ. Сүүлийн үед тус бүсэд мал маллаж амьдарч байгаа хүмүүст тулгамдаж болзошгүй нэг асуудлыг уул уурхайн үйл ажиллагаа эрчимжиж буй үйл явц гэж тайлбарлаж байна. Уул уурхайн үйл ажиллагаа тус бүс нутагт явагдаж эхлэвэл малчдын малын бэлчээр болоод байгаль орчны асуудал хүндэрэх магадлалтай гэж үзэж байна. Тэр дундаа Ноён уулын хойд ам болох Хөх Билүүтэй болон урд ам, Балжийн аманд зусаж байгаа малчдын хувьд энэ асуудал ихээхэн анхаарал татаж буй асуудал болж байна.

Тус бүс нутагт хээрийн судалгаа хийх явцад ажиглагдаж байсан нэг асуудал бол уул уурхайн компани болоод малчид хоорондын харилцаа тийм их биш байна. Энэ хирээр уул уурхайг ойлгох ойлголт бага, түүний үйл ажиллагааг үнэлж дүгнэх дүгнэлт муу байгаа нь анзаарагдана. Өөрөөр хэлбэл уул уурхайн талаар мэдлэг, мэдээлэл бага байгаагийн хирээр түүнийг эсэргүүцэх нөхцөл байдал бий болж байгааг харж болохоор байна.



Зураг 1 Гацууртын уурхайн талбай, нийтийн хэрэглээний замын эргэн тойрны соёлын өв бүхий газрууд

БАЙРШЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Сэлэнгэ аймаг нь 17 сумтай бөгөөд тус аймгийн хамгийн том сум болох Мандал сум нь Улаанбаатар хотоос 174 км зайтай оршдог ба 45 км сайжруулсан шороон замаар холбогдсон сум юм. Хан Хэнтийн нурууны салбар уул болох далайн түвшингээс 1000-2228.0 метр өргөгдсөн ой хээрийн бүсэд багтдаг. Тахилт, Урт, Тарвагат, Ноён, Хараа, Түнхэлийн хөх нуруу, Ширээ хошуу, Чивээ, Улааншавар, Матах, Мөнгөлөг, Хараагийн зэрэг 16 нуруугаар хүрээлэгдсэн 150 гаруй уултай, Хараа, Ерөө, Чулуут, Түнхэл гэсэн томоохон голтой, 120 гол горхитой, 136 булаг шандтай үзэсгэлэн төгөлдөр нутаг ажээ. Газрын өнгөн хөрсний хувьд уулын хагд, хиаг, хөвд, тал хөндийн нарийн ургамлан бүрхэвч бүхий ой, тал хээрийн бүсэд хамаарагдах, Монголын хойд зүгийн ойт бүс, Өмнөд Сибирийн ойт бүс нутгийн төгсгөл болсон бүс нутаг юм.

СОЁЛЫН ӨВД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, УЧИРЧ БОЛЗОШГҮЙ АЮУЛ:

Бид хээрийн судалгаа хийсэн бүс нутаг дахь уугуул иргэдийн дунд үе уламжлан тээгдэж ирсэн орон нутаг дахь тахилга, шүтлэгэт газар орон, уул овоод, хорио цээрт, хүндлэлт газруудыг нийтэд нь ерөнхийлэн *“ӨВТ ГАЗАР”* гэсэн категорит хамруулан үзэж байна. Учир нь хүний зүгээс уул овоод, газар оронд өгч буй өгөгдөл, түүнийг утгажуулж, амьджуулж байгаа нь тухайн газар орон бүрт хүний нийгэм соёлын түүхэн уламжлалыг бий болгож, түүнийг тэр нутгийн хүмүүс өөрсдийн нийгэм, соёлын нэгэн чухал элемент болгож байгаа нь үзүүлэх нөлөө, түүний нөхцөл байдлаас хамааран дээрхи үндсэн агуулгад оруулан тодорхойлсон.

Нийгмийн зүгээс үзүүлж буй янз бүрийн хүчин зүйлс, нөлөөллөөс шалтгаалан энэхүү “*өвт газар*”-уудад ямар нэгэн хэмжээгээр сөргөөр нөлөөлөх, түүний уугуул, үндсэн хэв шинжийг өөрчлөх, магадгүй устаж үгүй болгох нөхцөл бүрдэж байна. Уул уурхайн үйл ажиллагаа, тээвэрлэлт эрчимтэй явагдаж буй энэ бүс нутагт амьдарч буй нутгийн уугуул иргэд, малчдын амьдралын орчин, нутагшил ихээр түрэгдэн, шахагдах байдал ажиглагдсан учраас бидний хээрийн судалгаа хийсэн бүс нутагт нутгийн үндсэн оршин суугч малчид харьцангуй бага буюу бараг байхгүй гэж тодорхойлж болохоор байлаа. Тийм учраас бид хээрийн судалгаа хийх талбайн хэмжээг багагүй нэмэх шаардлага гарч байлаа. Учир нь аливаа уугуул соёлын үндсэн, үнэн зөв мэдээлэл нь орон нутгийн уугуул иргэдээр дамжигддаг учраас бидний судалгааны талбайн хэмжээ нэмэгдсэн юм. Орон нутгийн уугуул иргэд, малчид хоорондын зай холдож, тэдний амьдралын орчин ахуйн харилцаа багасах тусам тухайн нутаг орны талаарх түүхэн уламжлалт мэдлэг, шүтлэг хорио цээрийн уламжлал багасч байгаа нь ажиглагдаж байна.

Энэ хирээр нийгэм, эдийн засгийн нөлөөлөл эрчимтэй явагдаж буй өнөө үед уугуул соёлын элемент болох шүтлэг бишрэл дэх үнэлэмж, үнэ цэнэ үгүй болох, тахилга, хүндэтгэлт зан үйл үгүй болох нөхцөл бүрдэх боломжтой байна. Тэр дундаа уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт, дэд бүтцийн бүтээн байгуулалт болох төмөр зам, хатуу хучилттай зам зэргээр орон нутагт хийгдэж байгаа болоод хийгдэх их өөрчлөлт, хувирал нь тухайн бүс нутаг дахь ард түмний соёлын өв болсон газар орны үндсэн уугуул төрх байдалд сөрөг нөлөөллийг

үүсгэх, сөрөг үр дагаврыг бий болгох томоохон нөхцөл, шалтгаан нь болж болзошгүй юм.

ХЭЭРИЙН СУДАЛГАА ХИЙСЭН ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ:

Хугацаа: “Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Гацууртын орд орчмын нутагт хийх угсаатны зүйн судалгаа” төслийн хүрээнд тус нутагт 2015 оны 6 сарын 11-нээс 2015 оны 6 сарын 26 хүртэлх хугацаанд ажиллав.

Багийн бүрэлдэхүүн:

Хүснэгт 1 Судалгааны багийн гишүүд

Нэр	Албан тушаал
С.Чулуун	Судалгааны багийн ахлагч
Б.Бадма-Оюу	Судалгааны багийн гишүүн
Г.Бямбарагчаа	Судалгааны багийн гишүүн
М.Алтаншагай	Судалгааны багийн гишүүн
Р.Дондов	Жолооч

Судалгаанд хамрагдсан иргэдийн тухай:

Бидний хийсэн хээрийн судалгаанд хамрагдсан Хэрх-4, Мандал-5 багийн мэдээлэл өгсөн хүмүүс нь тухайн 2 багийн малчид, тариаланчид, нутгийн удирдлагын төлөөлөл, нийгмийн ажилтнууд багтана. Мэдээ өгсөн хүмүүс насны хувьд ойролцоогоор 30-75 насны хооронд байсан бөгөөд судалгааны шинж чанараас хамаарч хүйсийн харьцаанд анхаарал хандуулалгүй хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо аль болох нутгийн уугуул иргэдийг хамруулах, бүхий л насны төлөөлөл, ажил мэргэжил, боовсролын түвшингийн бүхий л хүрээг хамрахыг зорьсон болно.

Угсаатны зүйн судалгаанд Хэрх-4 багийн 20 айл, Мандал-5, Түнхэл тосгоны 15 айл, Бороо гол орчмын 7 айлын нийт 55 хүн хамрагдсан бөгөөд үүнээс нутгийн уугуул айл - 9, Завхан аймгаас - 3, Дундговь аймгаас - 2, Ховд аймгаас - 7, Архангай аймгаас - 3, Увс аймгаас - 4, Баян-Өлгий аймгаас - 2, Баянхонгор аймгаас - 3, Хөвсгөл аймгаас – 4, Говь-Алтай аймгаас – 3 буюу нийт 10 аймгийн 31 сумын гаралтай иргэд хамарсан болно. Насны хувьд 31 – 80 насны 28 эр, 14 эм, дунджаар 50-55 насны иргэдтэй уулзаж ярилцлага авчээ. Яс үндсийн хувьд халхын боржигин, олхунуд, харчин, шарнууд зэрэг овгийн иргэд дийлэнх байсан ба энэ нь тус аймаг хуучин Түшээт хан аймгийн харъяа буюу үндсэн хүн ам халх байсантай холбоотой юм. Бусад угсаатны бүлгийн хувьд торгууд – 1, баядын харагчууд, тайжууд овгоос тус тус – 1, тувагийн соён овог – 2, казахын жадык овог -2, хотонгийн шаавай элхэн – 2, ойрадын хойд овог- 2, монгол урианхан -1 хүн бүртгэсэн байна.

Ярилцлага авсан нутгийн захиргааны төлөөлөл:

1. Хэрх 4-р багийн засаг дарга А.Дашзэвэг
2. Хэрх 4-р багийн захирагчийн албаны дотоор хэргийн ажилтан Н.Отгончимэг
3. Хэрх 4-р багийн соёлын төвийн ажилтан П.Сайнтуяа

4. Хэрх 4-р багийн орон нутгийг судлах музейн ажилтан Г.Чулуунбаатар
5. Мандал-5, Түнхэл тосгоны засаг дарга С.Раднаабазар
6. Мандал-5, Түнхэл тосгоны иргэний бүртгэлийн ажилтан Н.Ариунгэрэл
7. Мандал-5, Түнхэл тосгоны соёлын төвийн дарга Ц.Байгалмаа
8. Мандал-5, Түнхэл тосгоны байгаль орчны хамгаалагч н.Нэргүй

Хээрийн судалгааны нөхцөл байдал:

Биднийг хээрийн судалгаа хийх нийт хугацааны туршид байгаль цаг уурын онц аюултай үзэгдэл тохиолдоогүй бөгөөд цаг агаарын нөхцөл байдал харьцангуй тогтоон зарим өдөр ихээхэн халуун байсан. Цаг агаарын энэхүү халуун орчин нөхцөл бидний судалгааны ажлын үр дүнд ямар нэгэн байдлаар сөрөг нөлөөллийг бий болгоогүй. Бүс нутгийн газарзүйн онцлог байдлаас шалтгаалан хуурай салхи ихтэй, түүнээс үүдэн тоосжилт тодорхой хэмжээгээр бий болж байлаа.

Судалгааны арга зүй

Хээрийн судалгааг хийхдээ угсаатан судлалын хээрийн судалгааны ажилд өргөн ашигладаг асуулгын арга, ярилцлагын арга, задлан дүгнэх арга, ажиглалтын аргуудын ашиглаж байсан бөгөөд, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан арга зүйгээ тодорхойлж ажилласан болно.

Ярилцлага авсан нутгийн иргэдийн мэдээллийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2 Ноён уулын хойд амны иргэд

№	Нэр	Овог	Нас	Хүйс	Засаг захиргаа	Одоо нутаглаж буй газар	Уугуул нутаг
1	Норжмаагийн Мөнхтуяа	боржигин	40	Эм	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Завхан, Баянхайрхан
2	Юмжирийн Цолмон	боржигин	56	Эр	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Дундговь, Эрдэнэдалай
3	Лхамаагийн Батсүх	боржигин	61	Эм	Хэрх 4-р баг	Уртын ам	Ховд, Буянт
4	Бадарчийн Цэнд-Очир	боржигин	73	Эр	Хэрх 4-р баг	Багийн төв, сүүл толгой 1-25	Төв, Лүн
5	Баатарын Туяа	боржигин	57	Эм	Хэрх 4-р баг	Багийн төв	Сэлэнгэ, Баянгол
6	Гончигийн Доосой	олхунуд	64	Эр	Хэрх 4-р баг	Уртын ам	Ховд, Буянт
7	Донторын Сэр-Од	торгууд	50	Эр	Хэрх 4-р баг	Уртын ам	Ховд, Булган
8	Дамбасүрэнгийн Мөнхзаяа	боржигин	31	Эр	Хэрх 4-р баг	Уртын ам	Завхан

9	Чимэддуламын Ариунжаргал	Халх	52	Эм	Хэрх 4-р баг	Уртын ам	Архангай, Батцэнгэл
10	Найдангийн Пүрэвсүрэн	боржигин	63	Эр	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Төв, Борнуур
11	Намсрайн Довчин	харчин	80	Эр	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Дундговь, Сайхан-Овоо
12	Дугарын Одонгэрэл	Халх	59	Эр	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Төв, Батсүмбэр
13	Найдангийн Пүрэвсүрэн	боржигин	63	Эр	Хэрх 4-р баг	Уртын ам	Сэлэнгэ, Мандал
14	Ваанчигийн Тогмид	боржигин	51	Эм	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Баянхонгор, Баянговь
15	Ганбаатарын Бат-Эрдэнэ	олхунуд	68	Эр	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Ховд, Дарви
16	Норжингийн Цэнгэл	Тайж	66	Эм	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Ховд, Мөст
17	Одхүүгийн Дагвадорж	олхунуд	72	Эр	Хэрх багийн төв	Хэрх багийн төв	Ховд, Дарви
18	Сурмаагийн Дашмаа	Халх, угалз	70	Эм	Хэрх багийн төв	Хэрх багийн төв	Булган, Сайхан
19	Агвааны Цогтбаатар	Хөх шарт	39	Эр	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Завхан, Баянхайрхан

20	Даваасүрэн	боржигин	76	Эм	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Архангай, Хотонт
21	Равжирын Хишгээ	боржигин	52	Эр	Хэрх 4-р баг	Хөх Билүүтийн ам	Хөвсгөл, Цагаан-Уул

Хүснэгт 3 Ноён уулын амны иргэд

№	Нэр	Овог	Нас	Хүйс	Засаг захиргаа	Нутаглаж буй газар	Уугуул нутаг
1	Баяндалайн Даваажав	баяд	58	Эр	Мандал 5-р баг	Балжийн ам	Увс, Малчин
2	Ханагайтын Захай	жатык /казах/	65	Эм	Мандал 5-р баг	Балжийн ам	Баян-Өлгий, Өлгий
3	Балжхайн Цэрэн	Харагчууд /баяд/	67	Эр	Мандал 5-р баг	Балжийн ам	Увс, Хяргас
4	Тогтохын Чотон	Харагчин /баяд/	62	Эр	Мандал 5-р баг	Бага Буданч	Увс, Хяргас
5	Ласарын Галрагчаа	урианхан	64	Эр	Мандал 5-р баг	Бага Буданч	Говь-Алтай, Халиун
6	Гочоогийн Даваадорж	боржигин	55	Эр	Мандал 5-р баг	Бага Буданч	Архангай, Хайрхан
7	Равдангийн Хулганаа	Цагаан соёд /тува/	55	Эм	Мандал 5-р баг	Бага Буданч	Баян-Өлгий, Цэнгэл

8	Эрдэнийн Мөнхбат	шаавай элхэн /хотон/	54	Эр	Мандал 5-р баг	Бага Буданч	Увс, Тариалан
9	Муратын Илиэш	итэлэ	87	Эр	Мандал 5-р баг	Балжийн ам	Баян-Өлгий, Буянт

Хүснэгт 4 Ноён уулын зүүн урд үзүүр, Мандал 5-р баг, Түнхэл тосгоны иргэд

№	Нэр	Овог	Нас	Хүйс	Засаг захиргаа	Нутаглаж буй газар	Уугуул нутаг
1	Цэрэндоржийн Цэдэндорж	Түнхэл	56	Эр	Мандал 5-р баг	Түнхэл тосгон	Хөвсгөл, Бүрэнтогтох
2	Зонровын Буянтогтох	тува нар	70	Эр	Мандал 5-р баг	Түнхэл тосгон	Ховд, Буянт
3	Зашлангийн Лхагвасүрэн	боржигин	63	Эм	Мандал 5-р баг	Түнхэл тосгон	Сэлэнгэ, Мандал
4	Какений Мутагар	Жадык /казах/	76	Эр	Мандал 5-р баг	Түнхэл тосгон	Ховд, Булган
5	Насангийн Гомбосүрэн	халх	72	Эр	Мандал 5-р баг	Түнхэл тосгон	Төв, Батсүмбэр
6	Товуудоржийн Дамдинсүрэн	шарнууд	61	Эр	Мандал 5-р баг	Хайлааст	Хөвсгөл, Бүрэнхаан
7	Бордухын Энхтуяа	Боржигон-начин	61	Эр	Мандал 5-р баг	Хайлааст	Баянхонгор, Байдраг

Хүснэгт 5 ”Бороо Гоулд” уурхайн орчмын иргэд

№	Нэр	Овог	Нас	Хүйс	Засаг захиргаа	Нутаглаж буй газар	Уугуул нутаг
1	Шаравын Батмөнх	боржигин	65	Эм	Хэрх 4-р баг	Бороо гол	Сэлэнгэ аймгийн төв
2	Пунцагийн Чойжил	хойд	51	Эр	Хэрх 4-р баг	Гонир баг	Говь-Алтай, Тайшир
3	Бадын Батаа	боржигин	57	Эр	Хэрх 4-р баг	Бороо гол	Зүүнхараа
4	Сосорын Бад	боржигин	56	Эр	Хэрх 4-р баг	Бороо гол	Сэлэнгэ, Мандал
5	Чулууны Даваажаргал	боржигин	46	Эм	Хэрх 4-р баг	Алтан бороо бригад	Хөвсгөл, Бүрэнтогтох
6	Пунцагийн Долгорсүрэн	хойд	56	Эм	Хэрх 4-р баг	Гонир баг	Говь-Алтай, Тайшир
7	Лувсанжамъянгийн Эрдэнэчулуун	боржигин	57	Эр	Хэрх 4-р баг	Гонир баг	Сэлэнгэ, Мандал

МОНГОЛЫН УГСААТНЫ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсад орчин цагийн угсаатны зүйн шинжлэх ухаан үүсч хөгжөөд даруй 50 гаруй жилийн түүхэн уламжлалтай томоохон салбар болон хөгжиж иржээ. Монголын угсаатны зүйн судалгаа бол эрт цагаас уламжлалтай дотоодын төдийгүй олон улсын эрдэмтэн судлаачдын ихэд сонирхдог салбар юм. Угсаатны зүйн судалгаа орчин цагийн шинжлэх ухаан болж хөгжсөн нь Монгол улсад анхны шинжлэх ухааны байгууллага болох Судар бичгийн хүрээлэн байгуулагдсан 1921 оноос эхтэй. Энэ үед монголын олон ястны гарал угсааны талаарх анхны бүтээлүүд гарч эхэлсэн юм.

Угсаатны зүй, этнографи /рус./, ethnology /eng./ гэдэг нь хүн ардыг судлах ухаан гэсэн утга илэрхийлэх бөгөөд олон үндэстэн ястны угсаа гарал, түүхэн тархалт суурьшил, тэдгээрийн харилцаа холбоо, эдийн болоод оюуны соёлыг судлахад чиглэгдсэн шинжлэх ухаан юм. Угсаатан зүйн судалгаа тухайн орны, нутгийн ард түмний ахуй соёл дээр газар дээр нь тулгуурлан явагддаг учиртай. Энэ чанараараа ард түмний хэв заншлын түүхийг хойч үед уламжлуулан таниулах явдалд хамгийн тустай хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнийг бэлтгэж түүх судлалын санд үлэмж нэмэр хандив болгон үлдээдэг онцлогтой шинжлэх ухаан билээ.

Угсаатан гэх ойлголтыг “түүх, хэл, соёл, амьдрал ахуйн хувьд бие биетэйгээ ойр төрөл, нэгэн угсаа гаралтай хүмүүсийг угсаатан гэнэ” хэмээн ерөнхийд нь тодорхойлдог. Угсаатны бүрэлдэх үйл явцын үндсэн хэлбэр нь үндэстэн юм. Угсаатны хамгийн бага нэгж нь овог бөгөөд удаахь нэгж нь ястан болно. Ястан нь нэгдмэл аялга, зан заншил, аж ахуй, нутаг дэвсгэр бүхий овгуудын нэгдэл /халх, өөлд, буриад гэх мэт/ юм. Харин үндэстэн бол нэгдсэн нутаг дэвсгэр хил хязгаар, соёл зан заншил, эрхлэх аж ахуй, бичиг үсэг, нэгдмэл нэг хэл, үндэсний ухамсар бүхий хүмүүсийн нэгдэл бөгөөд Монгол үндэсний угсаа гарал, угсаа соёлын асуудлыг судлахад Монголын угсаатны зүйн судалгааны үндсэн зорилго чиглэгддэг.

Угсаатны зүйн судалгаа бол аливаа угсаатан, угсаатны бүлгүүдийн антропологийн дүр төрх, угсаа гарал, тархан суурьшилт, түүх, хэл, ахуй соёл, нийгмийн байгуулал, гэр бүлийн харилцаатай холбоотой бүхий л мэдээлэлд ямар нэг онолын гаргалгаа хийхийг чухалчлалгүй байгаа байдлаар нь системтэй тоочин гаргахыг зорьдог. Иймд илүү дүрслэлийн шинжтэй салбар гэж хэлж болно.

Угсаатны зүйн хээрийн судалгааг экспедицийн журмаар явуулах бөгөөд агуулга хийгээд төрлийн хувьд гурав хуваагдаж үздэг.

Нэг. Явуул судалгаа. Энэ судалгаа нь богино хугацаанд тухайн газар нутгаар явахдаа соёл ахуйн онцлогийг өнгөц тэмдэглэх, дараа дараагийн судалгааны төсөл, сэдэв олох оршил судалгаа болдог.

Хоёр. Сэдэвчилсэн судалгаа. Энэ нь явуулын судалгааг бодвол сэдвийн хувьд гүнзгий, нэг газар нутагт удаан хугацаагаар байж угсаатны зүйн бүхий л

асуудлуудаар нарийвчилсан асуулгын дагуу хэрэглэхүүн бэлдэх зорилготой. Одоогоор Монгол улсын аймаг сумдын нутагт хийгдсэн угсаатны зүйн бүхий л тайлан хэрэглэхүүн нь энэхүү сэдэвчилсэн судалгааны дагуу хийгдсэн байдаг.

Гурав. Монографи судалгаа. Энэ нь ямар нэг үндэстэн, угсаатны бүлгийн түүхийг бичихэд чиглэгддэг. Үүний тулд судлаач тухайн нутгийн ард түмний дунд хэд хэдэн удаа сэдэвчилсэн судалгаа хийсэн байх шаардлагатай байдаг бөгөөд хэдэн жилийн үргэлжилсэн хөдөлмөр шаардагддаг бөгөөд үүний үр дүнд тухайн ястан угсаатны түүхийн чухал асуудлуулыг шийдвэрлэж өгсөн ном бүтээл бичигдэх учиртай.

Монголын угсаатны зүйн судлалын ухааны эх суурь тавигдахад монголчуудын удам угсаа, хэв хуулийн тухай хадгалагдаж үлдсэн сурвалж бичиг болон Орос хийгээд гадаадын жуулчин шинжээчин нарын тэмдэглэл зохиол хийгээд эртний Монголын тухай түүх, угсаатны зүйн холбогдолтой монгол, нангиад, араб, перс, европ хэлний сурвалж бичгийг шинжлэх ухааны хэллэгт оруулан ашиглаж үлэмж олон зохиол бүтээсэн гадаадын олон судлаач эрдэмтдийн бүтээлүүд нэн чухал хувь нэмэр оруулжээ.

Монголын нийгмийн байдал, угсаа соёл, ёс заншлын талаар үнэтэй баримт бүрдүүлсэн бүтээлүүдийн тоонд Оросын нэрт дорно дахиныг судлагч Н.Я.Бичурины нангиад сурвалж бичигст тулгуурлан бичсэн олон бүтээл, Оросын нэрт эрдэмтэн А.М.Позднеев, алдарт жуулчин Н.М.Пржевальский, Г.Н.Потанин, П.К.Козлов нарын замын тэмдэглэл болон нэрт жуулчин, угсаатны зүйч Г.Е.Грумм-Гржимайло, Орос-Зөвлөлтийн эрдэмтэн Б.Я.Владимирцовын түүх-угсаатны зүйн бүтээлүүд нэн ач холбогдолтой юм. Дээрх шинжээч судлаачид хийгээд тэднийг залгамжлагч олон орны монголч эрдэмтдийн бүтээл нь Монголын угсаатны зүйн нандин сан хөмрөг болж буй.

Монголын шинэ үеийн угсаатны зүйн судалгаа ХХ зууны эхэн үеэс Ж.Цэвээн, Г.Бадрах, Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Х.Пэрлээ, Ч.Далай зэрэг эрдэмтдийн бүтээлүүдээр тэргүүлэх ба харин өнгөрсөн зууны дунд үеэс угсаатны зүйн судалгааны эрчимтэй хөгжих шинэ үе эхэлсэн гэж хэлж болно. 1950-иад онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс угсаатны зүйн хээрийн судалгааны ажлыг тогтмолжуулж Хөвсгөл, Хэнтий, Ховд, Увс, Булган зэрэг аймгуудад угсаатны зүйн хээрийн судалгааны анги ажиллуулж дөрвөд, захчин, торгууд, урианхай, мянгад, буриад, халх, дархад, цаатан ардын талаар эрдэм шинжилгээний материал цуглуулах ажил шуурхай хийгдэж эхэлсэн бөгөөд шинэ үеийн төлөөлөл С.Бадамхатан, Г.Сүхбаатар, Ц.Гочоо, Ч.Хасдорж зэрэг эрдэмтдийн бүтээлүүд хэвлэгдэн гарч эхэлжээ.

1950-иад оноос угсаатан судлалын мэргэжлээр анхны боловсон хүчин ЗХУ-д мэргэжил эзэмшиж ирснээр монголын олон угсаатан ястнуудыг нарийвчлан судлах эхлэл тавигдаж, Монголын анхны угсаатны зүйн мэргэжилтэн С.Бадамхатан хээрийн судалгааны аргачлалыг монгол орны өвөрмөц онцлогт тохируулан боловсруулсан нь угсаатан судлалыг үндэслэх гол тулгуур болж өгсөн юм.

1959 оноос Хөвсгөл аймгийн дархад, цаатан ардын дунд угсаатны зүйн хээрийн сэдэвчилсэн судалгааны ажил зохион явуулсны үр дүнд дархад ястны бүрэлдэхүүнд байгаа самоед, турк, монгол угсааны овог аймгууд оролцсон болохыг тодруулж дархадын угсаа гаралын талаар нэн чухал баримтууд цуглуулж байсан юм..

1968-1970 онд Төв аймгийн Баянжаргалан, Дорноговь аймгийн Сүмбэр, Даланжаргалан, Айраг, Их Хэт, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдын боржигин халхын дунд хийсэн хээрийн шинжилгээний дүнд "Боржигин халх", "Боржигин найрын дэг ёс" зэрэг нэгэн сэдэвт бүтээлүүд хэвлэгдэн гарчээ.

1970-1980 оныг угсаатан судлалын мэргэжлийн боловсон хүчин төлөвшсөн үе гэж нэрлэж болно. Энэ үеийн судалгааны ерөнхий хандлага нь тухайн цаг үеийн нийгмийн байдалд нийцүүлэн монгол улсад социалист аж ахуй бүрэлдэн тогтож буй асуудал байсан хэдий ч энэ үеийн судалгааны гол амжилт бол монголчуудын угсаа гаралын асуудлыг хөндсөн эдүгээ судлаачдын ширээний ном болсон даацтай суурь бүтээлүүд олноор гарч байсан юм. Жишээлбэл, Монгол улсын угсаатны зүйн гурван боть суурь бүтээлийг санаачлан бичих ажлыг эхлүүлсэн нь монгол угсаатны түүх, оюуны болон эдийн соёлын хөгжлийг нэг хавтсанд багтаасан том амжилт байлаа.

Түүнээс хойш 1990-ээд оны эхээр монголын улс төр, нийгмийн өөрчлөлт энэ салбарыг тойрч өнгөрөөгүй, монголын ард түмний угсаатны хэв шинж, аж ахуйд нийгмийн байдал, шилжилт хөдөлгөөн зэрэг нь нөлөөлж эхэлснээр энэ салбарын судалгааг дэлхийн хөгжилтэй түвшинтэй хөл нийлүүлэх шаардлагатай байгааг сануулах болсон.

ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн 1981-1990 оны хооронд төлөвлөсөн суурь судалгааны хүрээнд "Монгол улсын угсаатны зүй" гурван боть суурь бүтээлийг туурвих ажлыг эхлүүлж 1987 онд тэргүүн боть болон "Халхын угсаатны зүй" бүтээл хэвлэгдэн гарчээ. Энэхүү сэдэвт судалгаа нь 1960-1970-аад оны үед явуулсан дархад, цаатан, боржигин халхын шинжилгээг үргэлжлүүлж монголын олон ястнуудын угсаа-соёлын асуудлыг цогцолбор аргаар мөшгин судлах эхлэл байв.

1986-1991 оны Түүхийн хүрээлэнгийн 5 жилийн сэдэвчилсэн төлөвлөгөөнд Ойрадын угсаатны зүйн судалгаа тусгагдаж Увс, Баян-Өлгий, Ховд сумын нутагт хээрийн судалгаа явуулж шинжилгээний хөтөлбөрийн дагуу тухайн ястнуудын угсаа гарвал, аж ахуй, эдийн болон оюуны соёлын холбогдол бүхий хэрэглэхүүн цуглуулан сэдэвчилсэн боловсруулалт хийсний дүнд дөрвөд, өөлд, торгууд, баяд, Алтайн урианхай, захчин, мянгад ястнуудын угсаатны зүй судалгааг иж бүрэн тусгасан "Монгол улсын угсаатны зүй"-II: Ойрадын угсаатны зүй /1996/ бүтээл хэвлэгдэн гарч нийтийн хүртээл болов. Ойрадын угсаатны зүй хэмээх энэхүү бүтээл нь өмнө хэвлэгдсэн халхын судлалаас ялгагдах өвөрмөц онцлог нь нэгд, Ойрадын угсаа түүхэнд мянгатын тогтоц нь хожмын дөрвөн Ойрадын улс төр-нийгмийн харилцааны үндэс болсны зэрэгцээ цаг төрийн байдлаас эзлэх байр суурь нь солигдож байсан (цорос өөлдөөр, торгууд хойтоор гм), хоёрт, Ойрад түмэнд XII-XIII зууны үеийн цэрэг ардчиллын байгууллын улбаа бараг XIX-XX зууны зааг үе хүртэл хадгалагдсан нь овог

ясны бүтэц бүрэлдэхүүн, ёс заншилд тодорхой тусгагдаж байсан, гуравт, Ойрад түмний хэлний аялгуу аж ахуй, эд өлгийн болон оюуны соёлд дундад эртний монголчуудын соёлын өв үлэмж өвлөгдсөн зэрэг байдлыг тодорхойлсон ач холбогдолтой судалгаа болсон юм.

Монгол улсын угсаатны зүйн сүүлийн III боть буюу Буриад, барга, үзэмчин, дарьганга, хотон, тува-цаатан, тува- малчин, хамниган ястнуудын угсаатны зүй /1996/ бүтээл нь Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл, Баян-Өлгий аймгуудын зарим сумдад хийсэн хээрийн судалгааны үндсэн дээр бичигдсэн бөгөөд тэдгээр ястнуудын онцлогийн хувьд тэдгээр ястан, бичил бүлгүүдийн гол цөм нь Буриад ба Тувагийн Бүгд Найрамдах улс, Өвөр Монголын Уйгур, Шинжааны өөртөө засах оронд аж төрдөг иргэд ба эдгээр ард зон нь тодорхой нутагт суурьшин мал болон цаа бугын аж ахуй хөтлөхийн зэрэгцээ эртний уламжлалт ан гөрөө хийгчид байсан нь нийт монгол, түрэг, түнгүс угсаатны дунд түгсэн нийтлэг хэлбэр болон ахуй соёлд нь өвлөгдөн үлдсэн хадгалагдсан байдлаараа өвөрмөц гэдгийг харуулсан нь зохиолын нэг онцлог байв. Мөн Монгол улсын Увс, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл аймагт аж төрөн суудаг тува малчин, тува цаатан, хотон нарын түүхэн замнал, аж байдал, соёлын талаархи судлаачид, жуулчин эрдэмтдийн тэмдэглэл хийгээд монголын угсаатны зүйчдийн сүүлийн 30-аад жилд хийсэн угсаатны зүйн судалгаанд үндэслэн бичсэн байна.

Монголын угсаатны зүйн судалгааны нэгэн онцлог үе бол 1983 оноос “Гурван голын монголчуудын угсаа гарвал, угсаа түүх” сэдвээр эртний түүх, угсаатан судлал, археологи, антропологийн судалгааны цогцолбор хөтөлбөр боловсруулан 1985-1989 онд Төв аймгийн Эрдэнэ, Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Дадал, Биндэр, Батширээт сумдын нутагт хайгуул болон малтлага судалгаа хийж гурван мөрний сав газрын газар усны нэрсийг бүртгэн авч, Монгол хаадыг оршоосон Ихэсийн газар, Их Хоригийн дээсийг тогтоох, боржигин, тайчууд зэрэг язгуурын монгол аймгуудын нутгийг тогтоох зэрэг судалгааг Хэнтийн хан уулын сав нутагт хийсэн нь эдүгээ судалгааны үнэт баримт хэрэглэхүүн болж байна.

Тиймээс сүүлийн хорин жил бол судалгааны чиг хандлагын хувьд ч, судалгааны арга барилын хувьд ч, судлаачдын хувьд ч шинэ үе төрөн гарч ирж буй онцгой үе байлаа. Монголын олон ястны хувьд угсаатан судлалын сонгодог арга барилаар судлууштай, судлагдаагүй үлдсэн олон асуудлууд хойно үлдсэн. Ялангуяа соёлын биет бус өвийн судалгааг хийхэд зайлшгүй шаардлагатай хээрийн судалгааг явуулах аргачлал өнөөг хүртэл сонгодог хэлбэрээ хадгалж үлдсэн юм.

Өнөөгийн Монголчуудын материаллаг болоод оюуны соёл бүрэлдсэн түүх монголд олон ястан бий болж төлөвшсөн түүхтэй холбоотой. Монголчууд дотроо бие даасан олон угсаатны бүлэг болж төлөвшихөд түүхэн нөлөөлөл олон байсан. Цэрэг дайн, нутаг сэлгэн нүүх, байлдан дагуулал зэрэг нөлөөлөл угсаатны нэг бүхэл байсан нэгдлийг задрааж цаашдаа олон угсаатны бүлэг бүрэлдэх эхлэл тавигдсан.

XY-XYI зууны заагт монгол угсаатны хамгийн том ялгарал явагдсан. Энэ нь ойрадууд халхаас нүүдэллэн тусгаар болсон явдал байлаа. Гэтэл зүүн монголчууд хаан хөвгүүдийн хувь болон олон хэсэгт хуваагдаж жижигрэн бутарсаар 17-р зууны сүүл гэхэд Манжид бүрэн эзлэгдсэн байв. Манжийн үеийн засаг захиргааны зохион байгуулалт монголын олон угсаатны бүлгийн соёлын явцад зохих нөлөөллийг үзүүлсэн гэж хэлж болно.

Засаг захиргаа тогтоож халхыг дөрвөн аймагт хуваасаар нутгийн зааг ялгаа тогтож улс төр, эдийн засгийн төвд оршиж байсны хувьд халх соёл монголд зонхилж, баруун монголын угсаатны бүлгүүдийн хувьд илүү эртний байдлаа хадгалж үлдсэн байдалтайгаар угсаатны бүлгүүдийн бие даасан соёл хөгжих нөхцөл бүрэлдсэн юм. Одоогийн байдлаар Монгол улсад 20 гаруй угсаатны бүлгийн соёл, тэдгээрийн салбар соёлын судалгаа хийгдэж байна.

Сүүлийн хориод жил угсаатны бүлгүүдийн орон нутгийн шинжтэй соёлын болоод угсаа гаралын зааг ялгаа аажмаар арилж өөр хоорондоо ижилсэх, уусах явц түргэсч эхэлсэн нь монгол угсаатны дотор болж байгаа соёлын үйл явцыг нийгэм-соёлын антропологийн үүднээс судлахын зэрэгцээ биет бус оюуны соёлын өвийг хойч үедээ өвлүүлэн үлдээх арга хэмжээг эрчимтэй явуулах хэрэгтэйг сануулж байна.

Монголчууд биет бус соёлын арвин их өв сантай. Тэдгээрийн зарим нь дэлхийн соёлын өвд эхнээсээ бүртгэгдэж эхлээд байна. Тухайлбал 2005 онд монгол ардын уртын дууг “Хүн төрөлхтний аман болон биет бус соёлын ховор нандин өв”-д ЮНЕСКО бүртгэж авсан. Мөн энэ онд манай улсын язгуур урлагийн төрөл болох тууль, цуур хөгжим, биелгээг гурван төрлийг “Дэлхийн биет бус соёлын өв”-өөр бүртгэж авсан байна.

Сүүлийн үед Монгол Улсын Үндсэн хууль, төрөөс баримтлах соёлын бодлогод соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах тухай заалтууд ихээр нэмэгдэж байгаа. Морин хуур, уртын дуу, монгол хөөмий үндэсний хөтөлбөрийг боловсруулж тус хөтөлбөрийн хүрээнд хөөмий, уртын дуунаас гадна мөн боржигин дуу, төв халхын ерөөл, магтаал, буриадын алтаргана наадам зэрэг угсаатны бүлгийн онцлогийг хадгалсан соёлуудыг давхар хадгалж хамгаалах бодлого багтсан буй.

Сүүлийн жилүүдэд Монголын угсаатны зүйн судалгааны ач холбогдол улам өндөрсөж Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна”. 27.9-д “Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцана”. 27.10-т “Урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэс болно хэмээн заасны дагуу угсаатны зүйн авран хамгаалах ажил эрчимтэй хийгдэж байгаагийн нэг илрэл

нь энэхүү Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Ноён уул, Бороо гол орчмын угсаатны зүйн судалгааны ажил боллоо.

НЭГ. СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НИЙГМИЙН БАЙДАЛ

XX зууны эхэн үед Түшээт хан аймгийн Баатар вангийн хошуунд одоогийн Сэлэнгэ аймгийн Мандал, Түнхэл, Зүүнхараа хот, Баруунхараа, Баянгол, Дархан-Уул аймгийн Шаамар сум, Дархан хот, Төв аймгийн Батсүмбэр зэрэг сумдын нутаг харъяалагдаж байжээ.

Нутгийн ноёд дээдсийн угшил 1700-аад онд Автай сайн хаанаас өөрийн ууган хүү Өлзийтөд эзэмшил нутаг таслан өгч Түшээт хан аймгийн Халхын умард замын баруун гарын адгийн хошуу нэртэй явсан ба 1911 онд Богд хаан Түшээт хан аймгийн Баатар бэйлийн хошуу болгож 1916 оноос Баатар ван Наваан-Юндэнгийн хошууны харъяанд байжээ. 1924 онд Улсын анхдугаар үндсэн хууль батлагдсаны дараа аймаг хошуудын нэрсийг өөрчилж Богд хаан уулын аймгийн Ноён уулын хошуу болжээ. Ноён уулын хошууны хошуу тамгын газар одоогийн Гацуртын уурхайн хуучин суурь байсан газар мөн гэж нутгийн учир мэдэх хууччуул ярьж байв.

Хэрх уулын өвөрт Хэрхийн хийд төвлөн оршиж байсан ба хамба лам Баажав, гэсгүй лам Цэрэндорж нар тухайн хийдийг тэргүүлж байжээ. Хэрхийн хийдийн үйл ажиллагаа засал гүрэм хийхэд чиглэгдсэн байсан ба цам цамнаж, майдар эргэдэггүй байсан бөгөөд гол шүтээн нь Лхам бурхан байсан гэдэг. Тус хийдийн үйл ажиллагаа 1926 онд хаагдсан гэдэг.[1]

Нутгийн засаг захиргааны зохион байгуулалтыг шинэчлэх явцад Богдхаан уулын Ноён уулын хошууны Тунгалаг Мандал сум хэмээн 1924 онд байгуулагдаж 1938 он хүртэл Төв аймагт, 1938-1943 онд Сэлэнгэ аймагт, 1943-1959 онд эргээд Төв аймагт, 1959 оноос Сэлэнгэ аймагт тус тус харъяалагдаж иржээ. Богд хаант Монгол улсын үеэс Богдын тариалангийн сан байсныг 1923 оноос Улсын тариалангийн сан болгож байсан нь тус нутаг газар тариалан, мал аж ахуйн хосолсон нутаг байж ирснийг харуулдаг. Улсын тариалангийн сангаа дагуулаад Хэрхийн зүүн хойно Хараа голд Хараагийн татуурган дээр хоёр газар гурилын усан тээрэм ажиллуулж гурил гарган авдаг байжээ.

1950-иад оноос нэгдэлжих хөдөлгөөн өрнөхөд Тунгалаг, Баянгол, Цэцэрлэг зэрэг нэгдлүүд үүсэн байгуулагдаж 1959 онд сумаараа “Цэцэрлэг” нэгдэл болон нэгдэж тухайн үедээ Зүүнхараа хэмээх том сангийн аж ахуй, Цэцэрлэг нэгдэл, Спиртийн үйлдвэртэй томоохон сум болон хөгжиж байжээ.

1960 онд Ноён уулын зүүн талд, Хараа, Түнхэл голуудын бэлчирт Түнхэлийн мод бэлтгэлийн аж ахуй улс ардын аж ахуйн модон материалын зарим хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж газар нутгийн хувьд Төв аймагт харъяалагдаж байсныг 1965 онд Сэлэнгэ аймгийн харъяалалд шилжүүлж Түнхэл хороог анх байгуулж байжээ. Тус мод бэлтгэлийн анги модыг гараар вагонд ачдаг байсан хуучин ажиллагааг халж 1974 оноос кранаар ачиж эхэлсэн ба мод тээвэрт МАЗ-509 машиныг хэрэглэн модыг туушаар тээвэрлэх арга

[1] Нутгийн өндөр настан Б.Цэнд-Очир гуайн зааж өгснөөр Хэрхийн хийд оршиж байсан Хэрх уулын зүүн хойно Дэв гэдэг газар очиж үзвэл хийдийн туурь гэхээр зүйл үлдээгүй боловч улаан тоосгоны үлдэгдэл, ширмэн тогооны хагархай зэрэг байсан байж болзошгүй ул мөрийг судалгааны багийнхан олж үзсэн билээ

нэвтрүүлж үйл ажиллагаа нь улам боловсронгуй болж эхэлжээ. 1989 оноос З.Буянтогтох ахлагчтай мод бэлтгэл тээврийн анхны түрээсийн гэрээт бригад байгуулагдаж мод бэлтгэл, тээвэрт өөрчлөлт шинэчлэл хийж эхэлсэн бөгөөд мод бэлтгэл бүхэлдээ түрээсийн гэрээнд шилжин ажиллах болжээ. З.Буянтогтох гуай эдүгээ 70 насыг зооглон Түнхэл тосгондоо аж төрөн Мод бэлтгэлийн аж ахуйн түүхийг бидэнд хүүрнэн суусан билээ.

1959 оноос ЗХУ-аас мэргэжилтнүүд урьж ирүүлэн таримал сорт тариалах газар тариалан МАА-н дэвшилттэй аргуудыг нэвтрүүлэн өвс хадах морин станц, хоногт 1.5 тонн гурил тээрэмдэх тээрэм, 300 үнээтэй саалийн бригад, ердийн хэсэгтэй цуваа, морин завод зэрэг байгуулагдаж байжээ. “Порзон”, “Интернациональ” маркийн тракторууд анх удаа Монголд орж ирэн ЗХУ-ын тусламжаар бүрэн тохижсон үр тариа, төмс хүнсний ногоо, даршны ургамал, шилэн хүлэмж, үржлийн болон саалийн механикжсан фермүүд, мал аж ахуйн салбар бүхий улсын томоохон ууган аж ахуй хөгжсөн түүхтэй.

Газар нутгийн 70 хувийг ойн сан бүхий газар нутаг эзэлдэг нь 1960 онд Ноён уулын зүүн урд Хараа, Түнхэл голын бэлчирт төмөр замын Түнх өртөөг түшиглэн “Түнхэлийн мод бэлтгэлийн анги аж ахуй” байгуулах үндэс суурь болж Баянхонгороос 10 гаруй ажилчин, Жаргалант, Хүүлийн хаан, Баруун Хараа зэрэг газраас 20 гаруй ажилчин нэг рамтай, үхэр тэргээр уулнаас мод бэлтгэж эхэлсэн байдаг. 1965 оноос гараар бэлтгэдэг аргыг халж мод бэлтгэлийн ажиллагаа бүрэн механикжиж ККС-10 кран, 30 тн кран зэргийг суурилуулж модыг вагонд кранаас ачдаг болж төмөр замаар тээвэрлэхийн зэрэгцээ хаягдал ашиглах цехэд байшингийн болон хашааны бэлдэц, гэрийн хана, унь үйлдвэрлэн хэрэгцээт байгууллагад нийлүүлж байжээ. Тус мод бэлтгэлийн аж ахуйд Баян-Өлгий, Баянхонгор зэрэг аймаг хотоос казах иргэдийг олноор улсын томилолтоор ажиллуулж мөн цэргийн алба дүүргэсэн бүхэл салаа цэргийг томилон ажиллуулж байсан нь эдүгээ Түнхэл тосгоны үндсэн хүн амын нэгэн томоохон бүрэлдэхүүн болж өргөжжээ.

1961 онд Зүүнхараа орон нутгийн хот байгуулагдаж, 1994 оны шинэ үндсэн хуулиар Мандал сум /одоогийн Хэрх тосгон, Түнхэл тосгон, Зүүнхараа хот нэгдэж/ байгуулагдсан. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 5 баг, үүнээс 2 нь тосгоны статустай байсан бол 2010, 2011 онд аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын холбогдох тогтоолуудыг үндэслэн тус суманд Баянхангайн 6-р баг, Минжийнхангайн 7-р баг, Тарнийн 8-р баг, Баян-Арцатын 9-р багуудыг шинээр нэмсэн байна.

Зүүнхараа хотод 1400 га ногоо тарьдаг нэгж, мөн 1 га хүлэмжийн аж ахуй, 400 га хүнсний ногоотой усалгааны систем, илүү нугаламт гахайн ферм, 800 талын улаан үүлдэрийн үнээний механикжсан сүүний ферм, гурилын үйлдвэр зэрэг улсдаа анхдагч бөгөөд хамгийн том аж ахуйнууд бүгдийг энэ нутгийн уламжлалт ахуйн онцлог гэж хэлэхэд буруудахгүй болжээ. Учир нь тэдгээр аж ахуйд ажиллаж байсан хүмүүсийн үр хүүхэд мөн л хувиараа ногоогоо тарьж, тариа хурааж тэр бүхний залгамж болон амьдарч буй юм.

1992 оноос Зүүнхараагийн САА хувьчлагдаж 13 компани болон үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2013 онд сангийн аж ахуйн 90 жилийг Зүүнхараачууд ёслол төгөлдөр тэмдэглэжээ.

Хүснэгт 6 Мандал сумын үндэстэн ястны байдал \2010 оны байдлаар\[2]

Нэр	Нийт	0-14 насны	15-64 насны	65-аас дээш насны	Эзлэх хувь
Халх	22 607	6 559	15 199	849	91.3
Казах	380	94	269	17	1.5
Дөрвөд	287	64	197	26	1.1
Буриад	281	57	195	29	1.1
Баяд	374	102	256	16	1.5
Дарьганга	4		4		0.8
Урианхай	222	49	156	17	0.4
Захчин	117	22	80	15	0.3
Дархад	76	17	54	5	0.3
Торгууд	79	21	47	11	0.1
Өөлд	29	6	20	3	0.1
Хотон	49	18	31		0.1
Мянгад	27	8	16		0.1
Барга	3	1	2		0.001
Хотгойд	22	4	14	4	0.1
Элжигин	3	2	1		0.01
Сартуул	9	1	7	1	0.03
Тува	102	20	77	5	0.4
Хорчин	1		1		0.004
Чантуу	2		2		0.004
Хамниган	2			2	0.004
	24 752	**7 053**	**16 686**	**1 013**	**100**

Тайлбар: Мандал сумын ЗДТГ-аас гаргасан дээрх бүртгэл мэдээллийг харахад тус сумын хүн амыг нийт 2 үндэстэн, 20 гаруй ястан бүрдүүлж байгаа нь сонирхолтой байна. Үзэмчин, цаатангаас бусад Монгол улсын бараг бүх угсаатны бүлэг бүртгэгдсэн байгаа нь энэ нутгийн нэг онцлог гэж хэлж болно.

[2] *Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЗДТГ-ын ИБМТ-ийн 2014 оны мэдээгээр*

Халх, казахыг эс тооцвол энд шилжин суурьшсан дийлэнх иргэдийг Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн дөрвөд, баяд, урианхай, торгууд, хотон, тува иргэд эзлэх ба зүүн аймгийн нутгаас шилжин ирэгсдийн хөдөлгөөн бага байсныг харж болж байна.

Хүснэгт 7 Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5-р баг, Түнхэл тосгоны үндэстэн ястны байдал

Нэр	Нийт	0-14 насны	15-64 насны	65-аас дээш насны
Халх	3467	764	2606	97
Казах	336	88	235	13
Дөрвөд	31	5	25	1
Буриад	57	16	34	7
Баяд	90	24	62	4
Урианхай	7	1	5	1
Захчин	18	4	11	3
Дархад	11	-	10	1
Торгууд	7	2	3	2
Өөлд	4	1	3	-
Хотон	10	5	5	-
Хотгойд	3	-	1	2
Сартуул	7	1	6	-
Тува	5	3	2	-
Хорчин	1	-	1	-
Нийт	**4054**	**914**	**3009**	**131**

Тайлбар: Мандал сумын 5-р баг буюу Түнхэл тосгоны хувьд бусад багийг бодвол онцлогтой юм. Учир нь хүн амын нэлээд хэсгийг казах иргэд эзэлдэг нь Түнхэлийн мод бэлтгэлийн аж ахуйд казах иргэдийг олноор томилон авчирсантай холбоотой ажээ. Мөн цэргийн албанаас халагдсан казах иргэдийг мөн энд авчирч тус аж ахуйд улсын томилолтоор ажиллуулж байсан нь үүнд нөлөөлж ихэнх нь суурьшихэд хүргэсэн байна. Угсаатны бүлгийн хувьд Хэрх тосгонтой харьцуулахад харчин, элжигин, хамниган зэрэг овог тааралдсангүй, харин Балжийн ам, Бага Буданчийн аманд 1990-ээд оноос Увс аймгаас дөрвөд, баяд айл өрх олон тоогоор ирж суурьшсан гэсэн нутгийнхны яриа овгийн бүртгэлээс харахад тодорхой нийцэж байв.

Хүснэгт 8 Сэлэнгэ аймгийн Мандал сумын 4-р баг, Хэрх тосгоны үндэстэн ястны байдал

Нэр	Нийт	15-64 насны	65-аас дээш насны
Халх	808	750	58
Казах	1	1	
Дөрвөд	3	3	
Буриад	7	7	
Хатагин	2	2	
Урианхай	4	4	
Захчин	1	1	
Дархад	2	2	
Торгууд	2	2	
Өөлд	8	8	
Хотон	3	3	
Хотгойд	8	8	
Сартуул	8	7	1
Тува	1	1	
Харчин	8	8	
Хойд	3	3	
Олхунуд	17	16	1
Барга	1	1	
Элжигин	1	1	
Хамниган	1	1	
Баяд	1	1	
Нийт	**890**	**830**	**2**

1.

Тайлбар: Мандал сумын 4-р баг буюу Хэрх тосгоны 0-14 насны хүүхдийн овгийн бүртгэлийг олж авч чадаагүй тул насанд хүрсэн 16-аас дээш насны 881 хүний овгийн мэдээллийг шүүж үзсэн болно. Ингэхдээ ховор ганц нэг тохиолдох бэсүд, гучид, жалайр, түмэд, алаг адуутан, шарнууд, хар үхэрт, алаг адуутан зэрэг овгуудыг халх ястанд багтааж, олхунуд, харчин зэрэг хэд хэд тохиолдсон овгуудыг хүснэгтэд оруулав. Түүнчлэн ургийн овгийн нэрийг нутаг орны түүх, хөдөлмөр эрхлэлт, газар усны нэрээр авсан тухайлбал, баатар ван, тариачин, модчин, мандал, Түнхэл, ажиндай, баяндулаан гэх мэт овгийн нэрсийг халх ястны тоонд оруулан бүртгэсэн, мөн гаднаас нүүж ирэгсдийг илтгэх малчин, тариалан, бүрэнтогтох, хяргас, Галдан бошигт зэрэг овгуудыг тухайн нутгийн

дөрвөд, баяд, өөлд ястанд хамруулан тоолов. Иймд дээрх хүснэгтүүд статистикийн хувьд 100 хувь баттай бус Мандал сумын хүн амын үндэстэн ястны ерөнхий байдлыг харуулахыг зорьсон гэдгийг хэлэх хэрэгтэй. 1990-ээд оноос хойш тус сумын нутагт бусад аймаг сумдын нутгаас шилжин ирэгсдийн тоо эрчимтэй нэмэгдэж ялангуяа Завхан, Увс, Ховдын нутгаас хот суурин газар амьжиргаа бараадан ирсэн иргэдийн тоо олширч байгаад сүүлийн жилүүдэд намданги байдалтай болсон ажээ.

Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж

Мандал сум нь засаг захиргааны нэгжийн хувьд 9 багтай /үүнээс 2 баг нь тосгоны статустай/, Монгол улсын аймгийн төвөөс алслагдсан хамгийн том сум юм. Газар нутгийн хэмжээ 484 373 га, нэг хавтгай дөрвөлжин метр квадратад 5,3 хүн ногддог. Тус суманд 2014 оны жилийн эцсийн байдлаар Төмөр замчдын 1-р баг, Ширхэнцэгийн 2-р баг, Баянсуудалын 3-р баг, Хэрх 4-р баг /тосгон/, Түнхэл 5-р баг /тосгон/, Баянхангайн 6-р баг, Минжийн хангайн 7-р баг, Тарнийн 8-р баг ,Баян-Арцатын 9-р багийн нийт 7382 өрхөд 25693 хүн ам бүртгэгдсэн нь Сэлэнгэ аймгийн нийт хүн амын 24,41%-ийг эзэлж байна.

Хүснэгт 9 Мандал сумын газар ашиглалт

Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	136 708	28.22
Ойн сан бүхий газар	309 957	64
Усан сан бүхий газар	2 260	0.47
Тусгай хэрэгцээний газар	21 384	4.42
Тосгон, суурингийн газар	12 826	2.65
Дэд бүтцийн газар	1 238	0.24

Хүн амын тоо бүртгэл

Суурин хүн амын тоо 2014 оны эцэс гэхэд 25693 байсан ба хүн амыг нас хүйсийн бүтцээр нь авч үзвэл нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 49,8 эмэгтэйчүүдийн эзлэх хувь 50.2, 0-5 насны хүүхэд 12,1%, 6-15 насны хүүхэд 15,2%, 16-59 насны залуус 65,7%, 60-аас дээш насныхан 7%-ийг тус тус эзэлж байна.



Зураг 2 Мандал сумын хүн амын насны хуваарилалт

Хүснэгт 10 Мандал сумын хүн ам, багаар

Багийн нэр	Сумын төв	Тосгон	Хөдөө	Бүгд
Төмөрзам, 1-р баг	3 102		186	3 288
Ширхэнцэг, 2-р баг	2 826		109	2 935
Баянсуудал, 3-р баг	3 120		72	3 192
Хэрх, 4-р баг		2 219	810	3 029
Түнхэл, 5-р баг		2 792	442	3 234
Баянхангай, 6-р баг	3 181		27	3 208
Минжийнхангай, 7-р баг	3 326			3 326
Тарни, 8-р баг			982	982
Баян-Арцат, 9-р баг	2 499			2 499
Мандал сум	**18 054**	**5 011**	**2 628**	**25 693**



Зураг 3 Сумын хүн ам, оршин суух байршлаар

Хүснэгт 11 Сумын өрхийн тоо, багаар

Багийн нэр	Сумын төв	Тосгон	Хөдөө	Бүгд
Төмөрзам, 1-р баг	931		62	993
Ширхэнцэг, 2-р баг	802		31	833
Баянсуудал, 3-р баг	860		34	894
Хэрх, 4-р баг		773	130	903
Түнхэл, 5-р баг		808	115	923
Баянхангай, 6-р баг	876		12	888
Минжийнхангай, 7-р баг	911			911
Тарни, 8-р баг			345	345
Баян-Арцат, 9-р баг	692			692
Мандал сум	5 072	1 581	729	7 382



Зураг 4 Сумын өрх, оршин суух байршлаар

Мандал сумын өрхийн тоо



Зураг 5 Мандал сумын өрхийн тоо, 2004 - 2014

Шилжилт хөдөлгөөн

2014 оны байдлаар бусад аймаг хотоос бүгд 295 хүн шилжин ирж, 676 хүн шилжин явжээ. Шилжилт хөдөлгөөний байдлыг графикаар үзүүлбэл:



Зураг 6 Мандал сумын шилжин ирсэн, шилжин явсан хүмүүсийн тоо, 2011 - 2014

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, дундаж цалин

2014 оны жилийн эцсийн байдлаар нийт хөдөлмөрийн насны хүн амын 58,9% нь хөдөлмөр эрхэлдэг, 27,9% нь ажилгүй, 9,6% нь өдрийн ангид суралцдаг, 3,6%-ийг хөдөлмөрийн чадваргүй иргэд эзэлж байна. Нийт хүн амын 64,7

хувийг буюу 16883 нь хөдөлмөрийн насны хүн эзэлж, нийт хөдөлмөрийн насны хүн амын 49,6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн өмнөх оноос 23 хүнээр буюу 0,23 хувиар нэмэгдсэн бол ажилгүй иргэд 4703 болж 65 хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Нийт ажилгүй иргэдийн 12,3-ийг хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа иргэд эзэлж байна.

2014 онд 593 иргэн ажил хайгчаар бүртгүүлснээс 292 иргэнийг зуучилж, 247 байнгын ажлын байр, 197 түр ажлын байр бий болсон байна. Нийт бүртгүүлсэн иргэдийн 522 нь буюу 88% нь орон нутгийн иргэд байсан бол 12% нь бусад аймаг сумаас ирж бүртгүүлсэн байна.

Хүснэгт 12 Мандал сумын хөдөлмөр эрхлэлт

Үзүүлэлт	Хүн амын тоо бүгд	эмэгтэй
Ажиллагсад	9 952	4 707
ХЭА-нд бүртгэлтэй ажилгүйчүүд	593	327
Ажил эрхлээгүй	4 703	2 591
Хөдөлмөрийн насны суралцагсад	1 623	709
Хөдөлмөрийн чадваргүй	605	365

Ажиллагсдын тоо

Нийт ажиллагсдын 41,3 хувь нь ХХК-д, 29,4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 13,5 хувь нь төр төсвийн байгууллагад, 7,2 хувь нь төмөр замын байгууллагад, 8,6 хувь нь бусад байгууллагад ажиллаж байна. Нийт ажиллагсдын 34,23 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт, 35,9 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 29,87 хувь нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

Хүснэгт 13 Ажиллагсдын тоо

Үзүүлэлт	Бүгд	эмэгтэй
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	2 921	1 168
Нөхөрлөл	567	312
Хоршоо	219	131
Хувьцаат компани	12	4
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	4 113	1 922
Төрийн өмчит үйлдвэрийн газар	714	271
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	28	7
Төр, төсвийн байгууллага	1 344	874
Төрийн бус байгууллага	34	18

Сумын дүн	9 952	4 707

Өрхийн орлого, зарлага

Улс даяар явагддаг өрх нийгэм эдийн засгийн судалгаанд сар бүр сумаас 10 өрх сонгогддог бөгөөд судалгаанд хамрагдсан өрхөд 8000 төгрөгний урамшуулал олгодог. Манай суманд нэг өрхийн сарын дундаж орлого 347 мянган төгрөг байна. Амжиргааны доод түвшин 2015 онд 164,3 мянган төгрөг, нэн ядуу өрх 73 буюу нийт өрхийн 1 хувийг эзэлж байна.

Боловсрол

Ерөнхий боловсролын 12 жилийн бүрэн дунд сургууль 6, хувийн хэвшлийн 1, нийт 7 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 7 цэцэрлэг, Зүүнхараа политехникийн коллеж зэрэг боловсролын 15 байгууллага үйл ажиллагаа явуулж боловсролын байгууллагад 594 багш, ажиллагсад ажиллаж байгаа юм байна.

Сумын хэмжээнд ЕБС-д 20 төрлийн сонгон секц дугуйланд 3573 хүүхэд, СӨБ-д 9 төрлийн дугуйланд 1025 хүүхэд, Хүүхдийн ордонд-7 төрлийн дугуйланд 1012 хүүхэд, мэргэжлийн урлагийн байгууллагад 10 төрлийн дугуйланд 348 хүүхэд нийт 5958 хүүхэд хамрагдсан байна. Ерөнхий боловсролын 7 сургуульд нийт 4701 суралцагч суралцаж байна. Нийт суралцагсдын 49,97 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Мандал суманд сургуулийн насны буюу 6-17 насны 4776 хүүхэд байдаг бол нийт сургуулийн насны хүүхдийн 98,43 хувь нь сургуульд хамрагддаг ажээ.

<u>Ерөнхий боловсролын сургуулиуд</u>

1. Улсын тэргүүний 1-р бүрэн дунд сургууль – (1951 оноос)
2. 12 жилийн 2-р бүрэн дунд сургууль - (1951 оноос)
3. 12 жилийн 3-р бүрэн дунд сургууль - (1974 оноос)
4. 12 жилийн 4-р бүрэн дунд сургууль - 1972 онд ашиглалтанд орсон, Хэрх 4-р багт байршилтай, 320 хүүхдийн хүчин чадалтай тус сургуульд одоогоор 466 хүүхэд суралцаж байгаа нь сумын нийт суралцагсдын 9,9 хувийг эзэлж байна. Хүчин чадлаасаа 45,6 хувиар илүү хүүхэдтэйгээр, 48 багш, ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Сургуулийн дотуур байранд малчдын 38 сургач амьдарч байна.
5. 12 жилийн 5-р бүрэн дунд сургууль - 1978 онд ашиглалтанд орсон Түнхэл 5-р багт байршилтай, 320 хүүхдийн хүчин чадалтай тус сургуульд одоогоор сумын нийт суралцагсдын 11,3 хувь буюу 530 хүүхэд суралцаж байна. Хүчин чадлаасаа 65,6 хувиар илүү хүүхэдтэйгээр, 40 багш, ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.
6. Ерөнхий боловсролын 12 жилийн Билиг ДБ сургууль - (2002 оноос)
7. Тарнийн сургууль цэцэрлэгийн цогцолбор - (1982 оноос)

<u>Политехникийн коллеж</u>

Зүүнхараа хотын Политехникийн коллеж нь 1997 онд ашиглалтанд орсон, Минжийнхангайн 7-р багт байршилтай, 540 хүүхдийн хүчин чадалтай тус коллежид одоогоор 13 мэргэжлээр 395 оюутан суралцаж, 64 багш

ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Нийт суралцагсадын 135 нь буюу 24,2 хувь нь эмэгтэй суралцагч байна. Суралцагсдын тоо өмнөх жилийн мөн үеийнхээс 9,5 хувиар өссөн байна. Дотуур байранд жилд дунджаар 90 оюутан амьдардаг байна.

Хүснэгт 14 Нийт суралцагчид, мэргэжлээр

№	Мэргэжил	Нийт суралцагч	Үүнээс: эмэгтэй
1	Тогооч	61	49
2	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	32	32
3	Барилгын засал чимэглэлчин	54	28
4	Барилгын өрөг угсрагч	6	1
5	Авто машины засварчин	63	0
6	Хүнд машин механизмын засварчин	44	0
7	Гагнуурчин	59	0
8	Барилгын сантехникч	17	0
9	Хүнсний ногооны фермер, жолооч	15	4
10	Мал аж ахуйн фермер, жолооч	20	6
11	Ойжуулагч	8	6
12	Үсчин	11	9
13	Механик тракторын жолооч	5	0
Нийт дүн		**395**	**135**

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуй

2014 оны жилийн эцсийн байдлаар 437 малчин өрх, 1582 мал бүхий өрх, нийт 2019 өрхийн 115858 толгой мал, 1772 гахай, 2595 шувуу, 51 туулай, 78 бүл зөгий тоологдлоо. Тэмээ 3, адуу 1350, үхэр 4425, хонь 2890, ямаа 1075 толгойгоор өсч нийт мал 9,18%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт малын 32,9 хувийг хонь, 31,6 хувийг ямаа, 25,9 хувийг үхэр, 9,5 хувийг адуу, 0,1 хувийг тэмээ эзэлж байна. Нийт малын 46 хувь нь хээлтэгч мал байна.

Нийт малын 26 хувь нь буюу 30326 нь Хэрх 4-р багт, 17 хувь буюу 19145 нь Тарни 8-р багт, 14 хувь буюу 15669 нь Төмөрзамын 1-р багт, 13 хувь буюу 15277 нь Түнхэл 5-р багт, 12 хувь буюу 14036 нь Баянсуудалын 3-р багт, 8 хувь буюу 9590 нь Ширхэнцэгийн 2-р багт, үлдэх 10 хувь нь Баянхангайн 6-р баг, Минжийнхангайн 7-р баг, Баян-Арцатын 9-р багуудад байршиж байна.

Газар тариалан, хүнсний ногоо

Мандал сумын газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртөг 18 965 сая төгрөгт хүрч өссөн нь нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 15,5

хувийг эзэлдэг байна. Мандал сумын иргэд болон хувиараа бизнес эрхлэгчид хүнсний ногоо тариалж зарахаас гадна өөрсдийн хэрэгцээг бүрэн хангадаг байна. Жилд дунджаар 461,4 га газарт хүнсний ногоо тариалдаг бөгөөд нийт тариалалсан талбайн 41,2 хувийг байцаа, 26,4 хувийг лууван, 14 хувийг манжин, 13 хувийг сонгино, үлдэх 5,4 хувийг бусад төрлийн ногоо эзэлдэг ажээ.

Хүснэгт 15 Үр тариа, хүнсний ногооны ургац

Нэр төрөл	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Үр тариа	5 617,3	5 894,5	6 642	6 603,8	6 841
Төмс	653	730,5	790	734	700
Хүнсний ногоо	318,5	385,3	405	456,5	461,4

Ургац хураалт

Мандал сумын хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүд сүүлийн жилүүдэд 1 0281,7 тонн үр тариа, 8 499 тн төмс, 7 929,7 тн хүнсний ногоо, 50 тн жимс, жимсгэнэ, нийт 26 760,4 тн ургац хураан авч, 18 300 тн хадлан, 2 802 тн тэжээлийн ургамал, 470 тн сүрэл, 30 тн гар тэжээл бэлтгэж иржээ.

ХОЁР. УГСААТНЫ ЗҮЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ



Малчдын малын бэлчээрийн багагүй хэсэг тариалангийн талбайд хашигдах нь цөөнгүй үзэгдэл болжээ.

Хээрийн судалгаа хийсэн бүс нутагт орон нутгийн уугуул иргэд, малчид тийм их биш учраас уугуул соёл гэж нарийн тодорхойлох боломж бага байлаа. Гэсэн хэдий боловч тал бүрээс ирж суурьшсан хүмүүсийн ахуй байдалд хадгалагдах соёлын элемент, мэдлэг ухаан нь бидний судалгааны гол үр дүн, ач холбогдолтой зүйл болно. Мандал сумд дээр өгүүлсэнээр гол төлөв баруун аймгууд болох Завхан, Ховд, Баянхонгор, Говь-Алтай Баян-Өлгий, Увс зэрэг аймгуудаас нүүдэллэн ирэх хүмүүсийн тоо сүүлийн 40-50-н жилийн хугацаанд бараг тасралтгүй явагдсаар ирсэн байна. Энэ нь нэг ёсондоо нутаг нутгийн хүмүүсийн соёлын нийлэгжилтээс бий болсон соёлын нийтлэг хэв маяг буюу энэ бүс нутгийн соёлын уламжлалыг өнөө үед бий болгож байгаа гэж хэлж болохоор болжээ. Учир нь одоогоос 30-40 жилийн өмнө ямар нэг ажил эрхлэх зорилгоор энэ нутагт анх суурьшиж байсан хүмүүсийн хүүхдүүд өнөөгийн Мандал сумын үндсэн уугуул хүн гэж тооцогддог болсон нь соёлын нийтлэгийг бий болгох үндэс болж байна.

байна. Бүс нутгийн онцло Энэ сумын хөдөөгийн малчдын амьдралын гол эх үүсвэр мал аж ахуй хэвээр гоос хамаарч тэмээ тэр бүр малладаггүй, гол төлөв үхэр, хонь, ямаа, адууг голлон маллаж байна. Малчдын нүүдэл сэлгэх уртын зайн хэмжээ тийм хол биш байна. Жилд нүүх нүүдлийн тоо хэмжээ тийм их бус, хавар, намартаа үндсэн хоёр нүүдлийг хийх нь ихэнх малчдын нүүдлийн үндсэн тоо гэж ойлгож болохоор байгаа юм. Нүүдлийн тоо тийм их биш байгаа хамгийн



гол шалтгаан нь тухайн бүсийн багагүй хэмжээний талбайг эзлэх газар тариалангийн талбай нөлөө үзүүлж байгаа болно. Малчдын ярьж байгаагаар сумын төвд амьдардаг, газар тариалангийн талбайтай айл өрхүүд жил жилээр талбайгаа ээлжээр ашиглах ёстой гэдэг боловч сүүлийн 2 жилд дараалан талбай дээрээ тариалалт хийж байгаа учраас малын бэлчээр ихээр хумигдах шалтгаан болжээ. Энэ нь зуны дулаан улиралд уулын ам дагаж лагерьлаж буудаг малчдын хувьд томоохон бэрхшээлийг үүсгэх болсон байна.

Малчин Даваасүрэнгийн ярьж байгаагаар “Малчид уг нь нэг л ам руугаа малаа бэлчээнэ, будаа тариа их тарьдаг болохоор малын бэлчээр их хумигддаг, тэр будаа, тарианы талбай руу мал орох л юм бол татвар торгууль гэж авдаг болохоор хэцүү. Уг нь нэг жил тарьсан бол дараагийн жилдээ өнждөг л дөө, энэ жил будаа их гарсан болохоор энэ хавийн малын бэлчээр их бага болсон. Бороогийн уурхайгаас болохоор Шивэрт рүү явуулна гээд байгаа, тэр газар чинь өөрөө хулгай их, хангай их болохоор тэнд байна гэдэг хэцүү болж байгаа юм” гэж байлаа. Малчдын зүгээс энэ байдалд ямар нэгэн шийдвэрлэх арга, үйл ажиллагааг хийж хэрэгжүүлсэн зүйл одоогийн байдлаар хийгээгүй байна. Харин малчид аль нэг уулын аманд бууж, тогтмол зусаж, нутагладаг айлуудаараа (гол төлөв 10-20 айл) нийлж “нөхөрлөл” байгуулж, тухайн бүс нутагт явагдаж байсан уулын модыг хулгайгаар бэлтгэдэг байсан явдлыг зогсоох, малынхаа саасан сүүг тогтсон хугацаанд нэгдсэн журмаар зохион байгуулалттайгаар “Сүү” компани болон бусад хувийн компани, цехүүдэд худалддаг байна. Малчид сүүгээ өдөр болгон худалддаг бөгөөд зарах өртгийн хувьд улиралаасаа шалтгаалан өөр өөр байдаг. Зуны улиралд дунджаар нэг литр сүү 400-600 төгрөг болж, өвөл, хаврын сүү багатай үеэр үнэ арай өсдөг.

Зураг 7 Малчин Даваасүрэн

УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ УХААН

Бэлчээр ашиглах уламжлал

Сэлэнгэ аймгийн Мандал сумын хүн амын бүтэц, бүрэлдэхүүн ерөнхийдөө олон аймаг, сумын иргэд, тэр дундаа соёл, түүхийн өөр өөрийн онцлог бүхий хүмүүсээс бүрэлдсэн сум юм. Хэдий тийм боловч цөөнгүй урт хугацааг тус бүс нутагт ажиллаж, амьдарч өдийг хүргэсэн олон хүмүүс байгаа учраас соёл, түүхийн нэгэн өвөрмөц шинжийг өөртөө агуулсан байдаг. Тэр хирээр өөрийн гэсэн соёлын нийтлэг шинжийг бий болгож иржээ. Энэ бүс нутаг нь байгаль, цаг уур, газарзүйн шинж төрхийн хувьд бусад бүс нутгаас тодорхой хэмжээгээр ялгагдах учраас түүнийг дагасан хүмүүсийн амьдралын хэв маяг, уламжлалт мэдлэг ухааны онцлог дүр төрхийг харж болно. Энэ нутгийн иргэдийн хувьд мал хийгээд газар тариалангийн хосолмол амьдралын хэв маягийг агуулсан байдгаараа онцлог. Мал маллаж амьдардаг малчин хүмүүсийн хамгийн гол анхаарал хандуулдаг асуудал бол яахын аргагүй малын бэлчээр хийгээд түүнийг цаг улирлын байдалд нь харгуулан бэлчээр, нутгаа сонгох уламжлалт мэдлэг, дадал юм. Нутгийн малчдын ярьж буйгаар энэ бүс нутаг нь бэлчээрийн үндсэн 2 чиглэлтэй байна. Үүнд 1. тал хээр, хөндийн бэлчээр, 2. уул, уулын хяр, энгэр дагасан бэлчээр гэсэн үндсэн чиглэл байна. Дээр дурдсан үндсэн чиглэлийн бэлчээрийг сонгох гол шалтгаан нь тухайн бүсэд ургах ургамал, малын идэшийг ажиглан сонгосон явдал болно. Малчдын ярьж буйгаар “*Малд*

тохиромжтой ааг өвс, хиаг зэрэг их байна. Голдуу малд тохиромжтой өвс юм. Агийг бог мал их иддэг. Хиаг, Ааг өвс хоёр чанараараа ялгагдана. Ааг өвс бол арай халуун чанарын ба яргуйгаас түрүүлж ургана. Хөвдийг үхэр мал бод л голдуу иднэ. Айргаа бид монгол маягаар эсгэдэг байсан. Зуслангийн газрыг сонгохдоо нөмөр биш задгайдуу, уул усандаа ойр тийм газрыг сонгодог. Намар 10 сар хүргэж байгаад зуслангаас нүүнэ. Өвөл малынхаа усыг харзнаас авч хэрэглэдэг." "*Манай энэ хавийн газраар Нохойн хошуу, сөд өвс энэ хавиар ургадаг. Малын идэшний хувьд уулын энгэрээр хялгана, хиаг ургадаг. Яг ууландаа бол өвс гайгүй. Уулаар голдуу хөвд ургана, хөвд болохоор бод мал, тэр дундаа үхрийн дуртай идэшний нэг болдог. Манай энэдэхийн малчид зундаа усаа бараадаад голдуу уулын ам, хойноосоо задгай амаар их нутагладаг, малд сэрүүн, малчдад ч бас тийм их халуун биш, сэрүүн байдаг болохоор мал маллагаанд ч хэрэгтэй байдаг."* гэх зэргээр малын бэлчээрийн хуваарь, малын гол ургамал, идшийн талаар ярьж байна.

Хурдан морины соёл

Мандал сумын малчдын дунд хурдан морийг уяж сойх уламжлалт арга ухаан өнөө үед багагүй хэмжээгээр хадгалагдсаар байна. Орон нутгийн уяачид гол төлөв хэд хэдэн айлууд нийлж нэг гал болж морио сойх нь элбэг байна. Хурдан морийг наадам болохоор ойролцоогоор нэг сар гаруй хугацааны өмнөөс уяж, бага багаар уяанд нь дасгаж, хоол тэжээлийг нь багасгаж байгаад ойролцоогоор 1 сарын өмнөөс богино зайд үсэргээг хийж эхэлнэ. Ингэхдээ гол төлөв олон жил уясан, том насны морьдоо эхэлж үсэргэдэг байна. Анх хурдан морьдоо уяхдаа билгийн тооллын Нохой өдөр уяж, мориныхоо уяан дээр арц, хүж уугиулан, ариулж, ламаар хийморь лундаа сэргээх, аюул барцадас хамгаалах зорилго бүхий ном хуруулж, тусгай зан үйл хийнэ. Морь сойж байх хугацаандаа тухайн морины нөхцөл байдлаас шалтгаалан тарга хүч ихтэй бол түүний хөлсийг богино зайд нэлээн ширүүн явдлаар давхиулж хөлсийг нь авдаг. Ингэж хөлс авах хоёр төрөл байх агаад нэг нь битүү нэмнээгээр хучиж хөлс авах, хоёрт, задгай буюу нэмнээгүйгээр давхиулж хөлс авдаг арга байдаг. Авах хөлсний хэмжээ тийм их биш бол задгайгаар хөлс авдаг байна. Мөн морины биеийг өөр нэг арга нь усанд шумбуулж, дотроос нь хүйтэн жингээр биеийг нь хөнгөрүүлдэг байна. "*Ер нь бол мориныхоо гэдэсийг харж байгаад ерөнхийдөө тарган байвал заавал л хөлслөнө дөө. Ер нь бол сарын дотор л жигдэрнэ дээ. Сар гарангийн хугацаанд их сорь, азарга, соёлонгууд бол гайгүй болчихно. Сойж байгаа морь ханиад хүрвэл Манайх бол тогооны угаалтуур хийдэг боролгоныг усанд хийж буцалгаад, тэрийгээ усыг нь шүүж аваад уулгадаг юм. Үндсэндээ бол хандалж уулгаж байна гэсэн үг. Аль болох өтгөн байвал сайн байдаг юм*" гэж морь уяж, уралдуулдаг уяачид ярьж байна.

Уламжлалт эм эмчилгээний мэдлэг ухаан

Энэ бүс нутагт амьдарч буй иргэд байгалийн бүтээгдэхүүнийг эмчиглээ, сувилгаанд багагүй ашигладаг бөгөөд тэдгээр ургамал, байгалийн бүтээгдэхүүнийг хэрэглэх аргыг ч мөн ихээр ашиглаж амьдралдаа хэрэглэдэг байна. "*Нохойн хошуу хэрэглэнэ, адууны уруул гэж ургамал байдаг бөөрөнд сайн. Бас таван цулд сайн. Таван салаа, эгүүшин гэж эмийн ургамал байдаг. Төмсний улаан цэцэг гэж байдаг. Зүрхэнд сайн. Зүрх савласан үед сүүнд буцалгаж уувал сайн байдаг. Ганга түүнэ. Газрын хаг бас бөөрөнд сайн. Унаганы зуулт бас сахарын шижинд их сайн гэсэн. Үүнийг хатаагаад, нүдээд нэг аяга усанд нэг чимх хийгээд уувал их сайн гэдэг. Бүлээн усанд найруулж ууна. Гүү унагалах үед унага амнаасаа унагадаг. Гүү унагалангуут энэ унаганы зуултыг шувуу шүүрээд аваад явчихдаг. Адууны шивэр бас их биед сайн гэж ярьдаг. Тэр нойр булчирхай, сахарт сайн гэсэн. Гэхдээ ууж үзээгүй. Тэр шиврийг бол зорж авдаг*" гэж малчин Д.Одгэрэл ярьж байв.

Ан гөрөөний мэдлэг ухаан

Байгаль цаг уурын хувьд уулархаг, хангайн бүсэд хамаарагддаг учраас энэ сумын хувьд ан гөрөө элбэгтэй газар юм. Ан гөрөөний уламжлалт мэдлэг ихтэй ажээ. Ан гөрөө их хийж, холбогдох мэдлэг ухааныг багагүй хуримтлуулсан хүн бол сумын өндөр настан Цэнд-Очир гуай ярихдаа "*Бид нар гөрөөлж явахад хоорондоо хөхөө шувууны дуугаар харилцдаг байсан. Хамаагүй хоорондоо ярьж явбал амьтан зугатаачих гээд байдаг. Тиймээс чи одоо харих болж байна уу? Уулзах уу? Яах вэ гэж тэгж хөхөөн дуугаар харьцдаг. Нэг дуугарвал тэр, хоёр дуугарвал тэр, гурав дуугарвал чи антай юу гэж ярьж байгаа юм. Тэгж харидцаж сурахыг ахмадууд зааж өгсөн юм. Түүнийг хөхөөчлөх гэдэг. Түүнээс гадна чоно шиг улина гэж байна. Манай энд чоно шиг олон янзаар ульж чоно авчирдаг хүн байсан. Мөн бугын урам гэж байдаг. Цэвэгжав гуай бол бууныхаа замгийг аваад дотогш нь татаж дуугардаг. Тэгэхээр тэр уулын бүр цаана байгаа буга гарч ирээд чагнадаг. Буга бол согоотой буга, согоогүй буга, хөгшин, залуу гэж янз бүр. Согоотой бугыг жишээ нь чимээ өгч дуудвал нөгөө согооноос холдохгүй болохоор гарч ирж чагнаж байгаа юм. Согоогүй бугыг бол арай өөрөөр дуудна. Цэвэгжав гуай гэж элдэвтэй, авьяастай анчин хүн байсан. Тэр бол булганы чигийн буриад хүн. Түүнээс би хөхөөчлөхийг дуурайсан бас чоно улихыг дуурайсан юм. Би бол залуухан чоныг авчирж байгаа юм. Хөгшин чоно бол чи өөрөө хүрээд ир гээд ирэхгүй байгаа юм. Гөрөөс дуудна гэж байдаггүй. Харин дуурайж дуугарч болдог. Дуурайж сайн дуугарвал чоно л ирнэ. Гөрөөс байна гэж андуураад. Чоныг дуудахдаа, чоно, нохойн хошуу урт учраас гараа амандаа хийж дуугардаг. Чоно бол ер нь заавал салхин доогуур ирдэг амьтан.*

Гөрөөс бол голдуу буга, гахай хараад дуугардаг. Тэрийг гөрөөс буухирах гэж ярьдаг. Тэр нь энд юм байна гэж бусаддаа дохио өгч байгаа үйлдэл юм. Тэгээд

гөрөөс боохирох дууг гаргавал чоно гөрөөс байна гээд андуураад хүрээд ирдэг. Гөрөөс хужир мараанд их дуртай амьтан. Тэгээд хужирдаа ирэнгүүт өөр амьтан түүн дээр байвал тухайлбал буга, хандгай, гахай байж байвал бас тэднийг холдуулах гээд боохироод дэвхэрдэг. Тэднийг хөөх санаатай дуугардаг. Зэрлэг гахайг бол дуудна гэж байхгүй. Тэр зэрлэг амьтан учир сонор сэрэмж их сайтай. Тэгсэн хирнээ мярайгаад ойртохоор харж байгаа мөртлөө анзаардаггүй, таньдаггүй. Бт 10м ойртойж очиж байсан. Олон гахай байвал мэдэхгүй. Харин мэдвэл аюултай. Би 8 гахайн дээр очиж байсан. Гахай тэгээд нэг дохиж хамраараа дуугаараад бусаддаа чимээ өгөөд пир хийдэг. Гахайны нэг онцлог гэвэл, төрсөн үеэрээ тооройнуудаа дагуулаад битүү ширэнгэнд том овоохой барьж орхидог. Тэр нь хоёр талдаа онгорхойтой. Бороо шороо нэвтэрнэ гэж байхгүй. Чоно ч тийшээ орохын аргагүй. Тэгээд дотор нь новш дэвсэнэ. Торойнууд нь тэнд байдаг. Тэгээд нөгөө торойнуудаа хамгаалаад битүүгээ дагаж идээшилдэг амьтан. Өвөл бол идэх юм олдохгүй болвол энгэрийн өвс иддэг. Тэгээд хамгийн түрүүнд нар тусдаг газар новшоо дэвссэн хэвтэж байдаг. Тэгээд нараа дагаа л идээд байдаг. Өвс иддэг амьтан. Хашир гөрөөчнийг дагаж байж л гөрөөний хэвтэр, байршил зэрэгт суралцдаг юм. Ер нь гөрөөлөхдөө байршлыг мэдэж байж л гөрөөлнө. Хаврын цагт бол гөрөөлөх хэрэггүй байдаг. Тэр үед бол үр төл нь гарчихсан жаахан нялх төлтэй, зарим нь хээлтэй тийм учраас хаврын цагт хэцүү байдаг юм. Зун бол 8 сарын 1-ээс гөрөөлөх үе нээгддэг байсан.

Баавгай бол хөхөөн дуунаар хөөцөөн орж эхэлдэг. Хөөцөө нь орж эхлэхээр нэг эвшний араас 10 баавгай дагачихсан явж байсан гэж хүн ярьж байхыг сонссон. Би хараагүй. Хамгийн том хүчирхэг нь эвшээ авч байгаа юм. 3 сарын үед л баавгай төрдөг. Баавгай голдуу 2 бамбарууш гаргадаг. 3 бамбарууш бас гаргана. Сүүгээр эхэлж тэжээнэ дараа нь энгэр дээр гарна. Тэгээд өвсний үндэс идүүлээд том болгоно. Тэгээд халиар гарахаар халиар идүүлнэ. Тэгж байтал жимс гарна. Тэгэхээр жимс идүүлнэ. Тэгж явдаг. Баавгай бол хүн гарахын аргагүй газар ичээгээ барьдаг. Би баавгайны ичээ зөндөө л харж байсан. баавгайны ичээ дотроо ойр хавийн өвс, хөвд авчраад 3 үе давхарлаад дэвсчихсэн байгаа юм. Их хүйтрэхийг мэдсэн баавгай ойр хавийн бүх мод, өвсийг авчирж овоолоод дотроос нь гадагш нь түрээд нүхээ бөглөсөн байдаг. Маш өндөр урт хөлтэй амьтан. Хандгай бол хамгийн өндөр цараамтай газар байдаг. Царам гэж өндөр уулыг хэлдэг. Тэгээд шөнө нь дандаа горхи руу бууна. Торлог гэж байна. Тэр торлогийн үзүүрийг иддэг. Тэр их халуун чанарын ургамал. Цас малтаж өвс иднэ гэж байхгүй. Торлог л иднэ. Тэгээд шөнөжингөө идэж байгаад нар гаруут царам руу гардаг. Хандгай бол буга, гөрөөс шиг өвс идэж явахгүй. Буга, гөрөөс бол өвс идэж явад тал руу гаа буучихдаг. Буга, гөрөөстэй бол хөөцөлдөөд байна. Хандгайг бол чадахгүй байгаа юм" гэж ярилаа.

Уламжлалт шүтлэг бишрэл, хорио цээр

Мандал сумын нутагт, Хэрх уулын зүүн урд өвөрт Хэрхийн хийд гэж жижиг хэмжээний хийд байж байгаад 1930-аад оны төгсгөл үед нураагдсан байна. Мөн сумаас зүүн урагш Түнхэл тосгоны ойролцоо Түнхэлийн хийд гэж байж байгаад мөн тэр үед нураагдсан ажээ. Тиймээс энэ бүс нутаг нь эртнээс нааш буддын шашны лам хуврагууд олонтой, шашин, номын үйл ажиллагаа

эрчимтэй явагдаж байсан газар юм. Одоогийн байдлаар сумын төвд нэг хийд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 3-н лам үндсэн үйл ажиллагааг хариуцан явуулж байна.

Мандал сумынханы дунд өргөн тархаж, үе дамжигдсаар байгаа нэгэн зүйл нь уул овоог тахих, түүнийг шүтэн бишрэх явдал юм. Тус сумын иргэдийн ярьж байгаагаар Ноён уулыг социалист нийгмээс өмнөх үед жил бүр тогтмол тахиж байгаад 1990-ээд оны эхэн хүртэл завсарлажээ. Харин тахилгыг дахин сэргээх санаачлагыг Мандал сумын иргэн Дагвадорж гуай анх 1992 онд дахин эхлүүлж, өмнө нь тус сумын Хэрхийн хийдэд шавилан сууж байсан лам Лувсандорж гэдэг ламаар эрт үедээ хэрхэн тахиж байсан зан үйлийг нь дахин хийлгэсэн байна.

Зураг 8 Ноён уулын дээд овоо, Хаан оргил

"Овоог тахихдаа, Өглөө очоод овоогоо тойрood, суугаад ном уншдаг юм. Овооныхоо урьд талд. Шүүс, идээ их авч гардаг. Тийм улсууд ч зөндөө байсан. улсууд архи аваад очдог. Архи болдоггүй юм шүү хүүхдүүдээ гэж хэлнэ. Тэрийг нь хүмүүс тоодоггүй байсан. Тэр лам их удаан уншиж байсан. Би өөрөө бол уг нь Сутай хайрханы бэлийн хүн. Тэгээд номоо уншаад дуусаад 4 зүг 8 зовхистоо лам юмаа өргөнө."

Ноён уулыг өмнө нь урд талаас нь буюу Балжийн амны талаас гар тахидаг байсан бол сүүлийн жилүүдэд урд талд нь уурхай нээгдэж байгаа учраас уламжлал алдагдаж хойд талаас нь гар тахидаг болжээ. Мөн сүүлийн жилүүдэд гарч буй нэг онцлог зүйл нь тахилгад бөө нар оролцох болж, тахилгыг зарим жилүүдэд бөө нар олноор ирж тахидаг болсон байна. Үүнийг нутгийн иргэд тийм ч сайнаар хүлээж авахгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. Мөн Ноён уулаас гадна сумын хойд талд орших Их, Бага Мандал уулыг мөн тахиж байсан бөгөөд өнөө үед ч жил тутам тахиж байгаа ажээ. Ноён уулыг эртнээс нааш энэ нутгийн хүн зон багагүй хүндэлж, түүнтэй холбоотой хорио цээрийн талаар янз бүрээр ярих нь олонтаа тохиолдоно. Жишээ нь Ноён уулын ойр орчмын уулуудад ой хээрийн түймэр цөөнгүй удаа гар байсан хэдий ч яг Ноён уулын орчимд дөхөж очиход бороо юм уу цас орчихдог гэж нутгийн олон хүн ярьж байлаа. Энэ бол нутгийн иргэд Ноён ууланд хэр хэмжээгээр хүндэтгэлтэй хандаж, түүнд гадны ямар нэгэн нөлөөлөл, сөрөг үйл ажиллагааг явуулахыг хэрхэн эсэргүүцдэгийг харж болох тайлбар юм. Биднийг хээрийн судалгаа хийж байх үед Ноён уулын тахилга болсон бөгөөд түүнд 30 гаруй бөө, хэд хэдэн лам нар оролцож, бөө нар уулын баруун доод суганд өглөө эрт зан үйлээ хийж, лам нар орой дээр нь ном уншиж байлаа. Бид зарим бөө нарыг онгод, сахиусаа буулгасан байх үед нь тус уулын эзэн савдагийг ямар дүр төрхтэй шинж байдалтай зүйл байгааг асуухад шувуу байдаг тухай хэлж байлаа. Эрт үеийн нутгийнханы ярьж буйгаар энэ уулын савдаг, эзнийг өндөр настай эрэгтэй хүн буюу өвгөн хүн байдаг гэж ярьдаг.

ГУРАВ. НУТАГ ОРОН, ТҮҮХТ ХҮМҮҮСИЙН ТАЛААРХ АМАН ТҮҮХҮҮД

Баатар бэйлийн тухай[3]

Баатар бэйлийг V богдыг залж явахад нь Монголд очиж тахь хэмээн Төвдөөс Гомбогүр гэж бурханыг өгсөн гэдэг. Тэгээд энэ бурханыг газар тавьж болохгүй шүү, дандаа барьж яваарай гэж захижээ. Гэтэл Өвөрхангай аймагт юм уу даа нэг тавьсан юм байна. Тэгээд тавьсан чинь Өвөрхангай, Архангайн аль нэг тийшээ Хар бухын голын тэнд унаа, хөсгийг нь бүгдийг нь хулгайч аваад явчихжээ. Тэгэхээр нь баатар ван нэг уулын орой луу гарч байгаад хэд хашгираадахсан чинь тэр улсууд хөсгийг нь авчирч өгөөд өршөө, бид таныг энд явсаныг мэдсэнгүй гэцгээжээ. Тэгсэн бэйл сэлмээ сугалаад азанд муу байх даа гээд ганцыг ч гэсэн өршөөж болохгүй байх гээд сэлмээ эргүүлсэн чинь хулгайчын толгойд явсан хүний толгойг тас цавчаад хаячихсан гэж. Тэгээд өнөө Гомбогүр бурханаа аваад явах гэсэн чинь наалдчихаад авч болохгүй байж. Тэгэхээр нь дуртай цээжийг нь би авья, дургүй бөгс нь газар үлдэг гээд цавчаад газарт нь үлдээгээд цээжийг нь аваад ирсэн гэж. Тэгээд Гомбогүр бурхан гэж тийм бөгсгүй цээж бурхан байдаг хэмээн домоглодог.

Тэгээд Хятадын хар цэрэг ирээд хотоор дайраад Түнхэл ороод ирсэн юм байгаа биз дээ. Тэгэхэд Баатар бэйл Дангаа нуураас харагдахгүй болохоор нь эмээл хөтөлийг харватал сэт харваад бүгдийг нь харваж алсан юм гэдэг. Өнөөдүүл нь зугатаад Орхон руу хүртэл элдэж хөөсөн гэнэ. Тэгээд араас нь баахан элдэж хөөтөл тэнд гамингууд үйгээд, ус нь гэв гэнэт үерлээд үхсэн юм гэнэ билээ. Тэгээд богд ламаас ч юм уу 50 лангийн ембүү Орхон руу хийж тахиж байсан юм гэнэ билээ. Хэдэн жил хийж байсан гэдэг түүх байдаг.

Тэр бэйл баатар их настай болсон байжээ. Ганц унадаг цагаан морьтой байсан. Түүнийгээ унаад л явдаг. Гэтэл түүнийг нь нэг удаа чоно идчихэж гэнэ. Тэгээд улсууд бэйл аавaа таны морийг чоно идчихсэн байна гэжээ. Өө бас хачин юм даа монголын халхын бор гөлөг миний морийг иднэ гэж баймааргүй юм. Цаг нь ч болж дээ. Бэйл аав нь ч нас өтлөөд явах болж дээ гээд ямар ч байсан би харья гээд мордоод явсаар байгаад нэг ухаа дээр гараад иртэл тэр ухаагийн цаана морийг нь чоно идэж байжээ. Аан за за гээд нум сумаа агсаад суусан байна. Тэгсэн өнөө цагаан морины толгойг нь тасдаж аваад цаашаа чоно нь яваад өгч. Том цагаан азарган чоно шиг юм аваад гүвээ даваад явчихаж гэнэ. Тийм байхаа, дэлт чоно л ирсэн байх түүнээс биш монголын бор гөлөг миний морийг идэх ёсгүй гээд тэгээд харвах гээд суугаад л байсан аж. Бэйлийн нүд юм харахдаа муу болсон байж. Унжсан зовхио модоор тэвхдэж байгаад тэгээд сумаа тавижээ. Бэйл аав ч одоо зөнөглөчихөж. Хэдэн гүвээ давсан юмыг яаж онох вэ гээд нөхөд ярьцгааж, бэйл за одоо буцацгаая, маргааш очиж сумаа аваарай, өнөөдөр авч болохгүй гэж. Тэгээд явчихаад өглөө эрт нөгөө залуучууд бэйл аавын сумыг л олохыг бодохоос тэр лав чоно алж чадаагүй гэж бодоцгоожээ. Тэгсэн чинь тэр чоныг яг аман хүзүүгээр нь хаа газар нь харваад сумаараа газар шаагаад нөгөөх нь таван ханатай гэрийн буурийн чинээ газрыг там болгосон байна гэнэ. Тэгээд маргааш нь үхсэн байхад нь очоод өнөө сумыг

[3] *Намсрайн Довчин. 80 н, эр, харчин, Хэрх IV багийн иргэн.*

авчраад таны сумыг авчирлаа. Таван ханатай гэрийн буурийн хэмжээтэй ухаад хаячихсан байна гэжээ. Тэгтэл тэгнэ тэгнэ, та нар хэрэв амьд байхад нь очсон бол чоно хүн харахаараа зориг ороод та нар руу дайрна гээд ийм учраас та нарыг хоно гэсэн юм аа гэж. Тэгээд тэр дэлт чоно гэдэг морийг нь идсэн юм гэнэ билээ.

Бэйл баатар өөд болохдоо би та нар дээр хүүхдийнхээ тоглоомоор ирнэ гэж хэлсэн гэдэг. Бэйл баатар нас бараад түүнийг оршуулах болтол хятадын нэг зурхайч ирээд сайхан газар оршуулна гээд нэг газар аваачаад тавьсан шарилыг нь хадан цохиотой уулын өвөрт тавь гээд тавиулсан гэдэг. Тэгсэн сүүлд өөр зурхайч нар үзээд бэйл баатар дахиж босохоос өнгөрсөн юм байна. Учир нь тэр шарилын газрын орой дээр хэрээ шиг хойшоо харсан газарт тавьсан байна. Тэр хэрээ тоншиж байхад тэр хүн босно гэж байхгүй хэмээжээ. Бэйл баатарын түүх тэгж дууссан юм гэнэ билээ. Түнхэлийнхэн тэгж ярьдаг юм. Нэг настай өвгөн ч надад тэгж ярьж байсан юм. Тэр бэйл баатарын морины толгойг тэр ажнайд авчирж тахиж байсан тэгээд ажнай хүлэг гэж тэр ажнай гэдэг нэрийг бэйл баатарын морины толгойны нэрээр нэрлэсэн юм гэнэ билээ гэсэн түүхтэй. Тэр ажнай гэдэг нь бэйл баатарын морины толгойг оршуулсан газрын аваачиж тахиж байсан гэдэг.

Естийн рашаан нээсэн тухай[4]

Өндөр гэгээн Занабазар Галдан бошготоос баруун талаасаа хөөгдөж яваад энэ Тарни гэж амралтын газар байдаг тэр Тарнийн дэргэд буудаллаад Занабазар гуай тарнийн арцаар тарнидсан юм гэнэ билээ. Тэгээд түүнд Тарни гэж нэр өгчээ. Ар Бэрхээр даваад өвөр Бэрх рүү буугаад Тайлжийн эхээр даваад цаашаа Этмийн гол уруудаад Хонгио өгсөөд явсаар Охид, хөвгүүд гэж нэг том хадан уул байдаг юм. Энэ нутгийн нэрээр бол Сэвчээ гозгор гэдэг ба Оросууд нэр өгсөн юм билээ. Түүнээс биш Чинчулуу гэдэг нэртэй. Тэгээд тэнд байхад нь Галдан бошгот гүйцээд ирэхэд нь цаашаагаа дүрвээд Естийн рашааны баруун хойно Юндэн, Тахилт гээд хоёр том ууланд очиж бүгжээ. Галдан бошгот хойноос нь нэхэж орж ирэхэд хоёр омогоос нэг охин, нэг хөвгүүн үлдээгээд хоёуланг нь хаданд үлдээгээд орхисон нь Охид, хөвгүүд гэдэг нэр авчээ.

Занабазарыг тэнд бүгж байхад хэвтүүл гэж харуулуудыг эргэн тойрон гарсан байхад нь морьтой хүн өмнөөс нь бууж ирээд бургас руу ороод алга болчихоод байжээ. Тэгээд нэлээн хугацаа болж байгаад эргээд мордоод явчихдаг байж. Түүнийг Занабазар гуайд хэлжээ. Хоёр, гурван удаа ингээд морьтой ирээд явлаа, яах вэ гээд асуухад Занабазар “Ерөөсөө та нар түүнийг алж болохгүй, чимээгүй бариад аваад ир” гэжээ. Тэгсэн тэр хүн омог дотроо хэрэг хийчихээд ууланд гарчихсан хүн энэ ууланд бүгсэн хүн байж. Естийн рашаан тэр үед их халуун байсан тул рашаанд ангийн махаа болгож идээд үлдсэн махаа болгоод борц болгоод богцлоод явдаг. Тэгээд авч явчихаад идэж дуусахаар нь дахиж ан агнаад ангийн махаа тэнд болгоод авч явдаг юмсанжээ. Тэгээд нэг орж ирэхэд нь нөгөө нөхрийг барьж аваад Занабазар гуайд аваачиж. Чи юун хүн бэ? Яасан хүн бэ гээд асуусанд би омогтоо хэрэг хийгээд ууланд дүрвээд гарсан юм гэжээ. Чи энд яагаад ирдэг юм гэтэл энд нэг халуун рашаан байдаг гэж зааж өгчээ. Занабазар тэр халуун рашааныг заалгаж аваад рашаан дээр нь очоод

[4] *Бордухын Энхтуяа. 61 н, эр, халх, боржигон-начин, Мандал Ү баг, Түнхэл тосгон, Хайлаастын ам*

рашаан бүгдийг нь ямар ямар эрхтэнд сайн байдаг гэдгийг бүгдийг нь нээсэн гэдэг. Естийн рашаан цагтаа Шаргалжуутын рашаан шиг их олон төрлийн рашаан байсан юм гэдэг.

Естийн рашаанаас цааш Гүүртийн нуруу гэж том нуруу байдаг юм. Ааяа гээд нэг том гол бий. Гүүртийн нуруун дээр зассан юм шиг асга байдаг бөгөөд Занабазар гуай дээгүүр нь тэмээ ачаатай яваад асган дунд хөлөө хийгээд зоогдоход нь нөгөө ширээ сандал энэ тэрээ эвдээд нөгөө асгыг чинь засаж барьж тэгээд цааш нь гарч байсан юм гэнэ билээ. Ааяагийн гол руу өнгийж харчихаад Занабазар гуай ааяа гээд уулга алдаж байснаас Ааяагийн гол гэдэг нэрийг авчээ. Тэгээд цаашаагаа явсаар урагшаа Биндэрийн овоогоор дамжиж явсан гэдэг юм билээ. Занабазар гуай тэр рашааныг нээгээд 3000 суварга хийсэн байгаа юм. Естийн рашааны тэнд жижиг үлдэгдлүүд нь байдаг. Өнөөх рашаанчид тэндээс очиж авдаг.

Түгж жанжин.[5]

Дээр үед ингэж байсан юм. Би эцгийнхээ ярьж байсан товчхон түүхийг ярьж өгье. Манай тэнд нэг ядуу хүү байж л дээ. Сайхан залуу ч байж. Гэхдээ бичиг үсэг мэддэггүй. Гэсэн чинь баруун 6 аймагт нөгөө эсэргүү хөдөлгөөн гэж гарч байсан юм дээр үед. Тэгсэн Түгж гэж, Та нар түүхээс сонссон байх. Тэр хүн тэр залууг орлогч жанжин болгоод авчихсан байгаа юм. Тэгээд эсэргүү ажил явуулаад байж баруун 6 аймагт. Тэгээд сүүлдээ улаан цэрэгт ялагдаад тэр Шархүү комиссар гэдэгт баригдаад, нөгөө орлогч залуу ганцаараа үлдэж. Нөгөө Түгжийг аваад явчихгүй юу. Мөрөнгийн голд аваачиж алаад. Тэгээд тэр улаан цэргийн дарга Шархүү комиссар гэж хүн байсан хэмээн манай аав ярьдаг. Тэгээд тэр хүн тэгсэн гэж байсан яахуу манай нутгийн ард түмэн гэж. Манай аавын аав дээр очсон гэж байгаа юм. Тэр Авирмэд гэдэг их сайхан залуу гэж байгаа юм. Бичиг үсэг мэддэггүй. Тэгсэн чи одоо амь гуй. Шархүү комиссараас очиж амь гуй гэж. Тэгсэн нөгөө залуу очоод хэлснийх нь дагуу амь гуйсан чинь. За за чи тэгвэл буугаа аваад ир тэгээд яваарай гэж хэлсэн байгаа юм Шархүү комиссар. Тэгсэн нөгөө залуу буугаа авчирч өгөх үед, нөгөө шар цэргийн үлдэгдлийг устгахад хэн явах вэ, хэн газарчлах вэ гэж. Одоо хэдэн хүн байгаа тэрийг хэн барих вэ гэж хэлсэн гэдэг. Тэгтэл би явья гэж тэр залуу хэлсэн байгаа юм. Гэтэл гаргаад буудчих наадхаа. Наадхи чинь улаанд ч хэрэггүй, шард ч хэрэггүй юм байна гэж хэлсэн байгаа юм. Ер нь манай түүхэн замнал тийм л сайхан шударга байсан байна.

Манай аав тэр Түгжийн тухай бичсэн ном сонинг уншаад дандаа буруу бичиж байна гэж ярьдаг байсан. Хөвсгөл аймгаас өр алдсан. Одоо юу гэж ярьдаг юм. Нэг нягтлан энэ тэр хийж байгаад өр алдсан тийм л нөхөр гэж яригддаг байсан талаар тийм нэг ногоон нүдтэй, жижигхэн бор хүн байсан гэж ярьдаг юм. Тэр бол бас нутаг усандаа үймүүлдэггүй хүн гэж байгаа.

Хүний зүрхээр яаж туг тахидаг юм бэ гэж намайг байцааж асуухад манай аав аав чинь ч гэсэн тэрийг мэдэхгүй тэрийг үзээгүй л гэдэг байсан. Сахал ах гэж нэг хүн байсан. Тэр Сахал ах хэлэхнээ, морины харуул дээр 100м газар орчим

[5] *Товуудоржийн Дамдинсүрэн. 61 н, эр, хотгойд, шарнууд, Мандал V баг.*

мориор чирэхэд л хүний ухаан балартдаг. Тэгэхээр авдаг байсан юм гэнэ билээ гэж ярьдаг. Тэгээд чирээд давхихаар ухаан балартана ш дээ.

Манай аав хэлдэг юм. Түгж гэдэг хүн жороо хул морио унаж явсан гэж байгаа юм. Манай Сангийн далай гэдэгт барьсан гэдэг. Тэр сангийн далай гэдэг уртаашаа 40 км газар. Түүнийг яаж барих вэ гэж нутгийн хүнийг дайчилсан юм гэнэ билээ. Манай аавыг дайчлах гээд яг мэднэ гэж байсан алба хашиж байсан тэр үед. Тэгтэл манай аав Түгжээс айдаг, нуугддаг байсан. Яагаад нуугдаж байсан гэхээр, манай аав баян хүний ганц хүү байсан юм гэнэ билээ. Тэгээд Түгжийг агтнаас нь хээр очоод 20 морь бариад уячихсан байнгуут аав нутгийн залуучуудтай очоод адуугаа салгаад авчихсан. Тэгээд сүүлд нь жанжин болсон гээд дуулдсан. Гэтэл Түгж манайд ирсэн гэж байгаа юм хаана байна тэр гэж. Тэр яг алах гэж ирж байхгүй юу. Гэтэл манай муу ээж залуухан, аавын түрүүчийн авсан эхнэр нь тэр Санжмтав ахын ээж байхгүй юу. Тэгээд тэр бас их баян хүний хүү байгаад шар өвчнөөр үхсэн юм гэнэ билээ. Манай ээж ядуухан хүний охин байсан, залуу хүний охин байхад нь аав аваад суучихсан гэдэг. Тэгээд Түгжийг ороод ирэнгүүт ээж үхсэн гэж хэлээдхиж. Тэгтэл цаадахь нь үнэмшсэн юм гэнэ билээ. Тэгээд дахиад Түгж ирээгүй. Түгж ирлээ гэхээр аав год гээд алга болдог. Эндээ/гэртээ/ нүх ухчихаад орж суудаг байсан гэж. Тэгэхгүй бол шууд ална, морио харамласан гээд. Тэгээд эсэргүүний жанжин болсон гээд. Тэгээд сүүлд нь барьсан байхад нь ч манай аав би харагдаагүй гэж ярьдаг. Толгой нь шархтай боочихсон, Жороо хул морийг нь Шархүү комиссар уначихсан. Тэр үнэхээр сайхан морь байсан гэдэг. Ямар амьтанаас ч дээрэмдэж авсан юм билээ гэж аав маань ярьдаг байсан.

Хойно цэргүүд Түгжийг хөөж яваад уулын бэлээс тэр цэргүүдээр дараад байхгүй юу. Хярлаа л. Түгж рүү морьтой цэргүүд нэг нэгээр буугаад байхгүй юу. Тэгтэл Түгж гүйцэгдээгүй гэсэн. Авирмэд нь морьтойгоо далай орсон гэж байгаа юм. Тэгээд гараад явчихсан гэдэг. Тэгээд тэр далай руу орсон Авирмэдийг үхчихлээ гэтэл маргааш нь амьд давхиад ирсэн би яахуу гээд явж байсан гэдэг. Түгжийг нь барьчихсан манай нутгийн тэр, манай өвөө тэгсэн гэж байгаа юм. Миний хүү энэ нутагтаа ч нэг гай болоогүй юм даа нэг аяга цай өгчих үү гэж Шархүү комиссарт хэлтэл, За дайсны чинь дараад явж байна. Та нар одоо айлтгүй за яахав нэг цай өгвөл өгчих гээд уулгачихсан морин дээр хүлээстэй, толгойгоо боолгочихсон тэгээд аваад явсан гэж аав ярьдаг. Дахиж үзэгдээгүй. Яахын аргагүй мөрөнгийн голд толгойгий нь аваад явсан байх гэдэг юм. Улааны цэрэг мөрөнгийн голд хуарагначихаад тал тал тийшээ явж бариад байсан гэсэн.

Тэгээд тэр Авирмэд амь гуйж явахдаа аавын аваас морь гуйсан гэж байгаа юм ядуу айлын хүүхэд болохоор. Тэгээд аавыг морь барьж өг гэсэн хоёр хоносон байдаггүй. Гурав дахь хоног дээрээ хүрээд ирсэн. Тэгээд буугаа аваад явсан. Буудуулчихаад тэрийг нь тэмдэг болгоод судрыг нь ганзаганд нь зүүгээд морийг нь хантаарлаад тавьчихдаг юм байна л даа. Тэгээд тэр морь хүрээд ирсэн гэж байгаа юм. Тэгээд манай аавын аав би л одоо ээжид нь очиж учрыг нь хэлэхээс гээд явсан байдаг. Тэгээд тэр судар энэ тэрийг тэр үеийн хөгшчүүл ч мэддэг байсан гэж байгаа юм.

Тэр эсэргүүний үед айлын тогоотой сүү хаяагаараа урсаад гарч байсан гэдэг. Эсэргүү ирлээ гэхээр дүрвээ л хаяад л явдаг. Тэр үед их буугаар хүртэл буудаж

байсан байгаа юм. Нэг уулын энгэрээс нөгөө уулын өвөр хүртэл нь бууддаг. Түгж өөрийгөө би бор гэгээн гэж өөрийгөө өргөмжилж анх олныг дагуулж орж ирж байсан юм гэнэ билээ. Тэгээд өөрийгөө бор гэгээн гэхээр тэр үед шүтлэг лут байсан учраас нөлөөлсөн байгаа юм.

Тэр Дэмид жанжин гэж аавыг цэргийн алба хааж байхад жанжин байсан хүн. Гэтэл Дэмид эсэргүү болж гэнээ гээд иймэрхүү хавтгай цаас багаар тарсан. Одоо бодоход хүнийг тэгж л алдаг байсан юм билээ гэж ярьдаг. Их хурц, тагжгар цагаан залуу байсан гэдэг. Манай аав --чигдлаар халагдаж байсан юм гэнэ билээ. Эсэргүү болохоургүй л хүн байсан юм гэдэг. Аавын аав нь хөвсгөлөөс тэмээ унаад 21 хоноод ороод ирсэн гэж байгаа юм. Яагаад гэхээр аавыг гадаадад сургуульд явуулах гэж байхгүй юу. Тэгээд эцэг нь халуулах гээд Хөвсгөлөөс ирсэн байгаа юм. Тэгээд Дэмид жанжин дээр ороод халуулж байсан гэж байгаа юм. Манай аав өргөмөл нөхөртэйгээ цуг байсан гэдэг. Гэтэл манай армид ардчилал гэж нэг ийм амьдрал хардаг юм болж байгаа юм аа хүү минь чамайг халья. Нөгөөхийг чинь халахгүй. Чи авгай хүүхэдтэй ч юм байна за сайхан амьдраарай гээд аавд нэг тамхи өгсөн гэдэг. Тэр нь нэг хайрцаг -- байсан юм. Тэгээд аавын аав дагуулаад тэр Дэмид жанжины өрөөнд цэрэг ороход л дэвхээд боссон гэж байгаа юм. Тийм генерал одоо бий юу. Тэгтэл хоёр шанааны нь үс зэрэг босч байсан гэж аав ярьдаг юм. Тийм сайхан жанжин байсан гэж

Сэлэнгэ аймгийн Мандал сумын газар нутаг уул усны тухай аман түүх сэлтийг Хэрх тосгоны иргэн өндөр настан, түүх сонирхогч, судлагч Бадарчийн Цэнд-Очирын[6] ярьснаас сийрүүлэн бичлээ. Өмнө дурдсанчлан Мандал сумын үүх түүх, аман түүх, хууч яриа мэдэх хүн үгүй болсон нь сүүлийн 20 гаруй жилийн туршид шилжин суурьшсан нутгийн хүн амын хөдөлгөөнтэй холбоотой юм. Хамгийн харамсалтай нь буусан уулынхаа ам, хавь орчмын нутаг усны нэрийг мэдэхгүй улсууд нэлээдгүй байсан юм.

Ширхэнцэг уул

Зүүнхараа хотын зүүн талд баруун хойноосоо зүүн урагш чиглэн тогтсон хоорондоо ойрхон зайтай Ширхэнцэг, Хэрх, Дууш хэмээх гурван уул байдаг. Эрт цагт нэгэн нутгийн жижиг уул Хангай хаантай марган мөчөөрхөөд “Би энд жижиг боловч их уулын бүх шинж төрхийг агуулсан байтал эндхийхэн намайг тоохгүй байна. Би ингэж том уулсын сүрд дарагдаж гуниглаж байхаар говьд очин Хайрхан хэмээн нэрлэгдэж хамаг олны хүндлэл хүлээж байх минь” гээд өмнө зүгт хөдөлжээ. Тэгэхэд нь Хангай хаан явуулахгүй гээд зогсоож, мөнөөх уул ч явна гээд зүтгээд байж. Тэгэхдээ орой бие нь урагш тэмүүлсээр байжээ. Хангай хаан аргадаж тайтгаруулсаар арайхийж зогсоож чаджээ. Харин өнөөх уул маань бэл, хормой гэх юмгүй цээж толгойтой урагш тэмүүлсэн ширсэн чигээрээ тогтсоноос энэ уулын “Ширхэнцэг” хэмээн нэрлэжээ. Ширхэн” гэдэг нь ширэх гэдэг үгнээс, “цэг” гэдэг нь цөг, боль гэсэн утгатай гэнэ.

Хэрх уул

Мөнөөх Ширхэнцэг уул явах гээд зүтгээд байхаар нь Хангай хаан ойр орчмоос нэгэн том уулын толгойг таслан авчирч урд нь хэрэн хөндөлдүүлж тавьжээ.

[6] *Боржигин Бадарчийн Цэнд-Очир. 73н, эр, Хэрх IY баг*

Тэгсэн ч Ширхэнцэг явах гээд зүтгээд дийлдэхгүй байж. Нөгөөх хэрж тавьсан уул маань Хангай хаанаас хэрхэх вэ гэж асуугаад байж. Хангай хаан хариуд нь хэрхэх юу байхав хэрээд бай гэж. Хэрх уулыг хүч нь хүрэхгүй байж магад гэж Хангай хаан хаширлаж бас нэг том уулын толгойг тасдан авч давхар харуул болгон зогсоогоод цаадахыгаа чухам нүд цавчилгүй тууш хар гэж хэлснээр тэр хар уулыг "Тууш нар" хэмээн нэрлэх болжээ. Энэ нь яваандаа Дууш болон хувирсан гэнэ.

Хараагийн Ноён уул

Эртний дээдсийн үед Монгол язгууртны ноёхон аймаг энд нутаглаж байснаас Ноён уул хэмээн нэрлэсэн.

Монголчуудын өвөг дээдэс, ноёдын шарилыг тойглон оршуулсан учраас илүү хүндлэх биширч ийнхүү нэрлэсэн гэх ба байр байдлын хувьд сууж буй ноён төрхтэй учир ийнхүү нэрлэсэн ч гэнэ.

Мичин модны гарам

Эрт цагт Монгол нутаг халуун дулаан уур амьсгалтай байхад арслан, заан, сармагчин гурав ах дүү болон амьдарч байжээ. Гэтэл гэнэт хүйтэрч ах дүү гуравт хөлдөж үхэх аюул тулгарчээ. Ингээд арслан ах нь хоёр дүүдээ "Нэгэнт хүйтэрч амьдрах нөхцөлгүй болсон тул миний хоёр дүү дулаан орныг бараад. Ах нь та хоёрын явдлыг гүйцэхгүй тул эндээ үлдэе" гэжээ. Гэтэл хоёр дүү нь бид таныг яахан орхиж явах билээ гэхэд арслан ах нь уурлан архирахад заан, сармагчин хоёр арга буюу явжээ. Хэсэг явсны дараа заан дүү сармагчиндаа "ах нь энд үлдэе чи цааш яв" гэжээ. Сармагчин хэсэг явснаа ер нь хоёр ахтайгаа хамт үлдэе гэж шийдээд бас л явж байсан газраа зогсчихжээ. Нэгэнт цаг уур хүйтэрсэн тул гурвуул тус тусын газраа хөлдөөд үхжээ. Арслан, заан хоёр уул нь Ширхэнцэг, Хэрх уул, харин сармагчин нь Хараа голын нэгэн гарам болжээ. Ширхэнцэг уулыг урдаас нь харахад хэвтэж буй арслан, Хэрх уул нь хэвтэж буй зааны төрхтэй харагддаг бол Хараа голд Мичин модны гарам нэртэй газар байдаг байна.

Зараа толгой

Мандал сумын баруун талд Бороо голын бэлчирт Зараа толгой, Баянсуудал, Баавгай хад хэмээх жижиг уулс бий. Урьд цагт Хараа, Бороо голын сав нутагт зараа Гомбо, эхнэр Баян нар хоёр хүүгийн хамт амьдран суудаг байжээ. Зараа Гомбо ганц гартай, маш уран хүн байж. Тэднийх Зараа толгойн өврөөс холдож нутагладаггүй учир Зараагийн суудал хэмээн нэршжээ. Баян эмгэнийг өөд болоход Зараа уулын өвөрт оршуулсан нь Баянсуудал нэртэй болжээ. Харин хоёр хүү нь эрийн цээнд хүрч өмнө зүгээс харийн дайсан довтолсон үед дайнд мордож, удсангүй дайн дуусч эр цэргүүд буцаж ирэхэд хоёр хүү нь ирсэнгүй. Хамт явсан хүмүүс нь Зараа өвгөнд гавъяа байгуулсан учир ирэх болоогүй гэж хэлжээ. Зараа Гомбо өндөр цохион дээр гарч хоёр хүүгээ харуулдан суухдаа хүүхдүүд нь амь үрэгдэж намайг хуурч байна хэмээн бодлогоширон ганцаар суусаар байсан толгойг Гомбын гозон толгой хэмээн нэрлэжээ. Энэхүү толгойг нар ургах зүгээс харахад үнэхээр өвгөн хүний дүрстэй байна. Олон жилийн дараа Гомбо өвгөний хоёр хүү баатарлаг гавъяа байгуулж харь нутаг хошуунд залагдаж яваад нутагтаа их бэлтэй ирж Баавгай харуул цохиондоо хадгалуулсан гэдэг домогтой.

Хараа гол

Эрт цагт Хэнтий хан Хурмастын дагинатай нөхцөж дотоод энгэртээ долоон охин, гадаад энгэртээ дөрвөн охин төрүүлжээ. Түүний гадаад энгэрээс төрсөн охид умард тийших аливаа бүх амьтныг ундаалах амьдралын эх болохоор ар тийш урсчээ. Тэр дөрвөн охин нь дөрвөн өөр зүстэй байж. Тэгээд тэднийг өнгө зүсээр нь дуудаж эрхлүүлдэг байсан ба хамгийн том нь ягаан зүстэй буюу яруу, удаах нь шар, гурав дахь нь хар, отгон нь бор зүстэй тул тэднийг Ерөө, Шар, Хараа, Бороо гэж дуудсанаас эдгээр голуудын нэр үүссэн гэдэг.

Хоёр Мандал уул

Зүүнхараа хотоос зүүн тийш Их, Бага хоёр Мандал уул бий. Тэдгээр уулсыг холоос харахад үнэхээр зориуд байгуулсан мандал мэт харагддаг. Өгүүлэх нь: Олноо өргөгдсөн Монгол улсын анхдугаар онд Богд хааны лүндэнгээр Хараагийн сав газрыг улсын сангийн тарианы талбай болгож, арвин их ургац авахын тулд уул усыг нь аргадаж тахилга хийн мандал өргөхдөө одоогийн Их, Бага Мандал уулын оройд есөн тансагийн идээ, есөн эрдэнэ оролцсон мандал бэлтгэн өргөөд тэр хоёр уулын хуучин нэрийг өөрчилж Их Мандал, Бага Мандал хэмээн нэрлээд лүүжинч лам Хараа голын дэргэд очоод “Хатан Хараа Ижий минь ээ, танд хоёр уулын чинээ мандал өргөлөө. Өргөл хишгээ жил бүр хайрла” хэмээн хэлээд шившжээ. Ийнхүү хоёр уул бүтэн биеэрээ Мандал болон мөнхөрсөн гэнэ.

Баянсуудал уул

Эрт урьд цагт Бороо голын адагт хоёр сайхан хүүтэй Баян гэдэг хөгшинтэй, амьжиргааны хэдэн малтай тал дээрх ганц уулын өвөрт өвөлжиж, ард нь зусаж явсан ганцхан баруун гартай Гомбо гэдэг өвгөнийх байжээ. Гомбо өвгөний хоёр хүү эрийн цээнд хүрээд байхад урд зүгээс дайны аюул нөмөрлөж эрчүүл бүгд эх орноо хамгаалахаар дайнд мордов. Баян хөгшний лагшин муудаж таалал төгсөхөд түшиж явдаг уулынхаа өвөрт хөгшнөө нутаглуулжээ. Дайн дуусаад хүмүүс ирэхэд өвгөний хоёр хүү ирсэнгүй. Танай хоёр хүү сайн тулалдаж баатрууд болсон, удахгүй ирнэ гэж хүмүүс хэлжээ. Өвгөн аав нь хүлээж ядсаар хамгийн өндөр уулын оройд гарч хүүхдүүдийнхээ явсан зүг харж суусаар хэдэн жилийг элээж дээ. Дайнд амь үрэгдсэн хүмүүсийг амьд мэнд гэж худал ярьсан байх нь, надад үлдсэн юм энэ ганц гар байна гэж гараа савсан чинь гар нь тасраад тээр хойно унажээ. Тайширын нурууг давах гэж баруун талаас нь өгсөж гарахад эргэдэг тойруугийн цаана зангидсан гар хадыг өвгөний гар гэдэг. Өвгөн Гомбо урагшаа харж суусан чигтаа хад болж оршжээ. Энэ бол Өвгөн Зараа толгой юм. Хоёр хүү нь дайнд ялсан дархан баатрууд болсон юм байж. Хоёр их баатруудыг аймаг хошуу дамжуулж залсаар хойт их гүрэнд заларчээ. Найр наадамд мансуурсан залуу баатрууд их бэлэгтэй нутагтаа ирэхэд хөгшин аав нь хүлээж ядаад хадан толгой болсныг үзээд авчирсан бэлгээ Хараа голын урд хаясан нь Хараа гол руу түрж орсон хадан цохиотой, урдуураа нам хөтөлтэй энэ уулыг бэлгийн уул гэнэ. Ах бид хоёр хөгшин эцэгтээ элбэрэл үзүүлж чадсангүй, аав минь маш их гомдож хадан толгой болж оршжээ. Хоёул нэг хадан толгой болж оршсугай гэжээ. Авчирсан бэлгийг харж бай гэж өндөр хадан цохио дээр баавгай тавьжээ. Гар хадны дэргэдээс харахад зүүн талын цохион дээр нэгэн том баавгай хадны цаанаас өрөөсөн хөлөө урагш тавьж, цээж нь

цухуйж харагдана. Энэ бол харуул баавгай юм. Баруун талаас өгсөж байхад замын хойно байдаг хадан толгойг Ах зараа толгой гэнэ.

Баян ээж минь, суудал хайрхан минь өнө мөнх үүрд жаргалтай яваарай гэж ерөөл тавьж үүнээс хойш Баян суудал нэр үүсчээ. Хараа, Бороо голын уулзварт байгаа толгойг Дүү зараа толгой гэнэ. 1912 оны 8 сарын 6-нд Хатанбаатар Магсаржав, Манлай баатар Дамдинсүрэн нараар удирдуулсан хамаг монголын зоригт эрчүүд Манжийн сүүлчийн амбаныг хөөн зайлуулж, айл болгон зул өргөж ах дүү хоёр баатарт зориулж зараа толгойн өвөрт хадан дээр хоёр маанийн үсэг сийлжээ. 1921 оны зун Их жанжин Сүхбаатараар удирдуулсан ардын журамт цэрэг Оросын улаан армийн дайчдын хамт Да Хүрээ рүү давших замдаа Дүү зараа толгойн ард цагаантны хэсэг хүчтэй тулгарч бут цохижээ. Энэ байлдаанд зориулсан ялалтын хөшөөг төмөр замын хойно довцог толгой дээр босгосон байдаг.

Хүүш Дашдаваа

Ардын хувьсгалаас өмнө хонхор хавьд нэгэн баяных байжээ. Тэр баяны гэргий насан өөд болж хоёр настай охин Дашдаваатайгаа үлджээ. Баян дахин эхнэр авч хоёр жилийн дараа охин төрж Ганжидмаа нэр өгчээ. Хойт эх нь Дашдавааг хажиглаж хялайсаар байгаад их ааштай адайр зантай болгож өсгөжээ. Дашдаваа ааш муу хэдий ч дүү Ганжидмаадаа их хайртай юмсанж. Хоёр охин нас бие гүйцсэн үедээ нэг залууд хайр сэтгэлтэй болж гэнэ. Нөгөөх залуу нь дүү Ганжидмаатай нь нууц ханилж, өөрийг нь тоосонгүй гэж Дашдаваа хоролхож аавдаа ховлож байгаад залууг ажлаас нь хөөлгөжээ. Ядуу залуу амьдрахын эрхэнд хятадын пүүсний үхэр хариулжээ. Зуны халуунд үхрүүд оодогнож нуур руу орж хоёр үхэр живж гэнэ. Пүүсний данжаадад үхрүүд нууранд живсэн гэж хэлж дээ. Дашдаваа үүнийг мэдээд танай хоёр үхрийг хүнд өгөөд явуулсан гэж хэлжээ. Ядуу залууг тамгын газраас баривчилж эрүү шүүлт тулгаж, ядуу залуу хилс хэрэг хүлээхгүй байсаар намайг үхсэний дараа нуур ширгэхэд үхрүүдийн эвэр цухуйж таараа, миний үнэн худлыг үзээрэй гээд өөд болсон гэдэг. Тэр нуурыг ядуу залуугийн нэрээр Дангаа гэж нэрлэсэн нь Ажнайн даваany урд бий. Харин дүү Ганжидмаа нь хайртай залуугийнхаа хойноос сэтгэл санаагаар унаж галзуурсан гэнэ. Эгч Дашдаваа нь хайртай дүүгээ хараад хичнээн их гай болсноо ойлгосон ч чадахын хирээр асарч тойглож байжээ. Ганжидмаа нь Дангааг дуудсаар байгаад алга болж Дангаа нуур хавиар хайгаад ч олсонгүй. Хараагаа уруудаж Гангад байхыг нь олж тэнд нь нутаглуулжээ. Хайртай бүгдээ хөнөөсөн Дашдаваа мөн галзуурч Ганганаа миний дүү эгчдээ ир, эгч нь түмэн буруугаа хүлээе гэж хашгирсаар байгаад алга болжээ. Дүүгийнхээ хойноос явлаа гээд Ганга хавиар хайгаад олсонгүй голынхоо зүүн талд Салхит ууланд таалал болсон байж. Дашдавааг тэнд нь оршуулж тэр уулыг Дашдаваагаар нэрлэсэн гэнэ. Хүүш уул, Ганга, Дашдаваа, Хүүшийн /Хараагийн/ гарам ингэж үүссэн гэнэ.

Ажнайн даваа

Дээр үед баатар бэйл нас өндөр болоод байхад нь чоно морийг нь идсэн гэнэ. Баатар нум сумаа зэхэж, жаахан хүү хажуудаа суулгаж сэгийг сахиж гэнэ. Чоно ирж, бор гөлөг миний морийг идэхгүй ээ гээд тоосонгүй. Үүр цайж байхад цагаан адуу ирлээ гэнэ. Нөгөөх нь морины сэгийг зууж мөрөндөө тохоод даваа өөд

явсаар гарлаа гэхэд харвасан гэнэ. Даваany цаад руу нэг том дэлт чоно ойчсон байв гэнэ. Баатар хүний аргамаг хүлгийн толгойг тавьсан учир Ажнайн даваа нэг өгчээ.

Буу толгой

Эрт цагт энэ нутагт Баянтогоо гэдэг эгэл олондоо алдартай, энгүй их бяртай залуу бөх байжээ. Жил бүрийн наадамд түрүүлсээр олон түмэндээ Баянтогоо аварга гэж алдаршжээ. Баянтогоо аварга нэг удаа намар ан гөрөө хийж яваад Минжээс цааш буриад айлын хүргэн болжээ. Өөрийнхөө жинхэнэ нэрийг цээрлэж Очир гэж нэрлэжээ. Тэр нутгийн баян охиноо өгөх дургүй байж, хойтон зун нь Баянтогоо аварга сэтгэлтэй бүсгүй Баянжаргалыгаа дагуулж Минжийн голыг өгсөж оргож гэнэ. Минжийн даваанаас наана хоёр зүр хүзүү өнгөрч явтал олон морьдын төвөргөөн дуулдаж нуугдаж өнгөрөөжээ. Баруун зүгийг барьж явсаар Ерөө голын уужим тохойд олон хоньтой айлд очжээ. Баянжаргал бие давхар тул цааш явахад хэцүү байж. Сайхан зантай эмээ өвөө хоёрынд саатан сууж гэнэ. Нэгэн өдөр өвгөн сандран ирж өнөөх хүмүүс буцаж явна нуугд гэжээ. Баянтогоо ухаан сэдэж ойрхон хорж зогссон олон хонины дунд Баянжаргалтайгаа нуугджээ. Баянжаргал удахгүй нярайлж гурван охинтой болов. Өвгөн хөгшин хоёр ихэд баярлаж хойтох тасархай толгойг тахиж “Охид толгой” гэж хишиг буйнаа хайрласан уудам тохойгоо “Хонин нуга” алдар хайрлажээ.

Баянтогоо аваргын нутагт газар доороос их ус ундарч нэлэнхүй усанд автжээ. Амьтай бүгд хорхой шавьж хүртэл уул өөд зүтгэж гэнэ. Энэ их уулаас гэтэлгэх ачтан хаана байна гэхээр нэг өвгөн Баянтогоо аварга маань байсан бол...аваргад хэл хүргэ гэж тагтаа шувууны хүзүүнд бичиг зүүж өгөөд явуулжээ. Баянтогоо аварга ирж өндөр уулан дээр гарч хад асгыг нурааж, ундарга болгоныг дарсаар нөгөөх уул намхан болжээ. Энэ ууландаа Баянтогоо хэмээх нэр алдар хайрлаж найр наадам хийж гэнэ. Баянтогоо аварга минь нутагтаа сууж байж гэхэд Баянтогоо тэнд намайг хүлээж байгаа хүмүүс бий. Намайг дуудах гэвэл энэ чулууг цохиорой тэгэхээр би ирнэ гэж Марзын амны баруун хамар дээр хэнгэрэг чулуу босгож тавьжээ. Хэл хүргэж ачилсан тагтаа шувуундаа зориулж хөшөө босгосон гэнэ. Маань чулууны хөтлийн хойт нуруун дээр баруун тийш харж суугаа тагтаа, дэргэд нь ангаахай нь байдаг. Баянтогоо аваргабуцаж ачлал өгсөн хоёр бууралтайгаа нүүж Минжид суурьшин суужээ. Өвгөн насан өөд болоход дээд талын давхар ууланд нутаглуулж Буурал хайрхан гэж нэрлэжээ. Гурван охин хөлд ороод байх үед Баянтогоо ан гөрөөнд яваад сураггүй болжээ. Минжийн голоо өгсөж захын цагаан оломоос дээш хадан цохионы өвөрт отоглоод байхад муу санаатан дээрээс нь чулуу буулгаж амийг нь хороосон ажээ. Баянжаргал гурав хоног уйлж суужээ. Тэр гацаа цохио уй гашууг нь шингээн авч салхилд уйлдаг тул уйлдаг гацаа гэдэг. Буурал хайрханы хормойд хоёр хадан цохиотой уулын өвөрт Баянтогоо аваргыг нутаглуулж “Очир богд” алдар хайрлажээ. Баянжаргал гэртээ харьтал гурван охин нь алга бүгд эрэлд явжээ. Нарийн гол өгсөж явтал нэгэн том шувуу юм идээд сууж байжээ. Энэ лав идэж байна даа гэж санаас очтол шувуу нисээд явчихаж гэнэ. Гурван охин нь түүхий мах зулгааж идээд сууж байв. Тэр том шувуу гурван охинд мах авчирч өгсөн юм байж. Тэр голыг Ёлын гол гэж нэрлэжээ. Гурван охин нь өндийж өсөж гурван сайхан хүүхнүүд болжээ. Тус

тустаа айл гэр болж суусан нутгийг Их ууханы хөндий, Бага ууханы хөндий гэдэг. Хожим ээж нь таалал болоход хойт энгэрт нь нутаглуулж хамар дээр овоо босгоэ Бүрэнжаргал овоо гэж нэрлэжээ. Нутаглаж байсан буурин дээр нь дугана босгосон гэнэ. Урд талын амыг нутаглаж байснаар нь бага охины нэрээр Бадамсан гэжээ.

Царамт[7]

Дээр үед сайн эрс гэж байлаа. Монголын сайн эрсийн чуулдаг байсан газар нь манай энэ Түнхэлд байдаг. Түнхэлд Царамт гэж газар байдаг юм. Тэгээд тэр Царамт дээр үед ерөөсөө битүү хар шугуй байсан юм билээ. Ер нь саяхан биднийг ирэхэд Царамтын хар шугуй гээд тэр аяараа битүү хар шугуй байдаг байсан. Хоёр, гурван удаа түймэрт өртөөд ийм болсон болохоос биш. Ерөөсөө монголын, халхын, өвөрлөгч талаасаа хүртэл сайн эрс зуны дунд сарын шинийн 15нд чуулаад бөөнөөрөө чуулган болдог байсан гэдэг. Үндсэндээ хурал гэсэн үг. Жилд нэг тэгж чуулдаг. Тэгээд энэ жил чи одоо ямар, ямар ноёнтой яаж, яаж тэмцэв гэж ярьдаг байсан байгаа юм. Тэгээд тарж яваад дараа жилийн тэр өдрөө цугладаг. Одоо тэр Царамтын орой бол нүцгэн толгой болсон. Манайд жил болгон тэнд очиж зүгээр нэг ах дүү нарынхаа дунд тахидаг нэг хэдэн хүн байдаг. Царамтын хар овоо гээд ар өвөргүй модоор битүү тийм газар байсан.

Гурван баян[8]

Эрт дээр цагт одоогийн Төв аймгийн нутаг Тосон заамарт адуу мал нь талдаа багтахаа байсан, алт мөнгө нь авдрандаа багтахаа байсан Тост баян гэгч байжээ. Тост баян төрөхөөс ганц охинтой, тэр нь эрхлэх нь ихэдсэн дурааараа өссөн юм байж. Тост өөрөө долоо дахь үеийн баян юм гэнэ. Баян байвч долоон үеэс цаашгүй, ядуу байвч гурван үеэс цаашгүй гэж үнэн юм даа, миний найм дахь үе энэ охиноор дуусах нь гарцаагүй бололтой яг ёрлож байна. Яаж найм дахь үеээ тогтоох вэ гэж бодож явдаг ганц шаналгаатай юмсанжээ. Хавь ойрын баян айлуудын хүүхдүүдийг хичнээн шинживч санаанд нь нийлэх нэг ч байхгүй. Харин Өлзийхүү гэдэг зарц залуу нүдэнд нь тун дулаахан харагдаад байв. Өлзийхүү нь ээж, ах гурвуул амьдардаг удахгүй амьдралаа холбох гэж буй сэтгэлтэй бүсгүй байдаг зэргийг мэдэж байв. Тост баян Өлзийхүүг эд хөрөнгөөр татах гээд чадсангүй. Өөр арга бодож гэнэ. Ид ес эхэлсэн дүн өвлийн хүйтэн өдөр Өлзийхүүг дуудаж хоёул уулзаж гэнэ. За хөө Өлзийхүү минь чи бид хоёр адилхан эр хүн, хэн хэнээсээ юу нуухав, эр хүн эр хүндээ хайртай байдаг. Би бол долоон үеийн баян, найм дахь үеийн ганц охинтой, сайн хань олж өгье гэж санасан юм, чи манай хүргэн болох уу гэжээ.Өлзийхүү нь чадахгүй гэж. Тост баян их инээж, хоёулаа бооцоо тавъя. Өнөө шөнө долоон гадаснаас далан тэмээг сондгой тоогоор уяж чадвал чамд далан тэмээний тоогоор далан лан алт өгье. Эс чадвал чи манай хүргэн болно доо гэж гэнэ. Өлзийхүү бодож байснаа найм дахь гадас байвал болох юм гэж. Тост бахтай инээж чи манай энэ шүдлэн говьд гадас байтугай ургаа чулуу ч олохгүй. Гадсаа олсон байхад болох юм. Гэхдээ тэмээнүүдээ бүгдийг нь байлгах ёстой. Би тэмээнүүдээ зүс нь

---

[7] *Бордухын Энхтуяа. 61 н, эр, халх, боржигон-начин, Мандал Y баг, Түнхэл тосгон, Хайлаастын ам*

[8] *Боржигин Бадарчийн Цэнд-Очир. 73н, эр, Хэрх IY баг*

байтугай үсийг нь харсан ч танина гэжээ. Орой нь урьдаас бэлдсэн долоон гадсанд далан тэмээг сондгой тоогоор уяхад нэг үлджээ. Өлзийхүү ганц тэмээгээ бүсээрээ ногтолж хонож гэнэ. Тост баян өглөө эрт босч гарч харвал тэмээнүүдийн хагас нь алга. Өлзийхүү бүсээрээ ногтолсон тэмээгээ хэвтүүлж хажууд нь суугаагаараа унтаж байх аятай харагдав. Тост баян Лүнхүүг дуудаж, цаад дүүгээ дууд, халуун цай уулга гэжээ. Гэтэл Лүнхүү амьсгаадан гүйж ирээд ахаа сүйд болж, яг таг гэв. Тост баян ухасхийж босоод яаран гарахад хүмүүс ч даган гарч гэнэ. Тост баян очоод хөөе босоорой гээд түлхтэл яг таг, өшиглөтөл ер хөдөлсөнгүй, Тост эвгүйцэж хөлдлөө гэхэд газарт зоосон гадас биш, яг таг байхдаа яахав дээ гэж хэлтэл хормой, дээлийн хормой сөхөгдөж Өлзийхүү гарч ирээд Тост гуай би арай ч хөлдөөгүй шүү гэжээ. Хүмүүс инээж Тост ч инээж чи найм дахь гадсаа олжээ. Харин тэмээнүүдийн чинь хагас алга шив. Би тэмээнүүдээ зүсийг нь байтугай үсийг нь ч танина. Үс нь алга гэж. Өлзийхүү тиймээ та тэгж хэлсэн, та үсийг нь хараад таних юм чинь тасраад үлдсэн бурантаг бүгдийг таних биз гэв. Тост баян бахтай инээж чи аргагүй сэргэлэн эр юм. Бооцоогоо авч чаджээ. Харин эр хүн эр хүндээ хайртай байдаг гэж би хэлсэн байх аа гэхэд Өлзийхүү нь тэгсээн гэжээ. Хэд хоногийн дараа билигтэй сайн өдөр хавийн хүмүүсийг цуглуулж найрлах болов. Гэрийн хойморт Лүнхүү, Өлзийхүү хоёрын дунд ээжийг нь суулгаж Тост баян дүүрэн сүүтэй том мөнгөн аяга хадагтай бариад:

Энэ сайхан хорвоод эд хөрөнгөөр элбэг яваа ч элбэрэлт сайхан хүнээс өөр эрхэм дээд хүн хаа ч үгүй юмаа. Би танай хоёр хүүтэй ах дүү болох хүсэлтэй байна, хүлээн авна уу гэж ээжид нь үнсүүлж, аягатай сүүгээ хуваж уужээ. Тост баян далан лан алтаа өгч, миний хоёр дүү төрснөөс өөрцгүй ганц эмэгтэй дүүгээ үеийн үед өөд нь өргөж туслаж яваарай гэж хэлжээ. Нэгэн өвгөн хадаг барьж:

Тост баян, чи аргагүй тос нь даасан заамар баян юм. Өөрөөсөө гадна хоёр баян төрүүлэв. Ах дүү гурван баян минь энэ сайхан нутагтаа олон түмэн биднийг үргэлж тэтгэж яваарай гэж хэлжээ. Лүнхүү нутгаасаа жаахан холдож арзгар толгойн дэргэд суурьшиж түүнээс хойш Дүн толгой нэр үүсчээ. Өлзийхүү Лүнгээс хойш уудам хөндийд суурьшжээ. Ах дүү гурван баян олон түмнийгээ үргэлж тэтгэж, нутаг орондоо ядуу хүнгүй болгосон учир Өлзийхүүд “өгөөмөр баян” цол хайрлажээ. Өлзийхүүгийн нутаглаж байсан хөндий Өгөөмөр нэртэй болсны учир ийм гэнэ.

Хятад иргэдтэй холбоотой аман түүх

Мандал сумын нутагт эртнээс алт хайгч гаднын хүмүүс ирэгсдийн зорьсон нутаг байсан нь зарим домогт хадгалагдан үлджээ. Тухайлбал, Зүүнхараагаас Түнхэл орох замд Майхан хэмээх майхан мэт харагддаг уул байдаг. Урьд нэг шунахай газар шинжээч тэнд буугаад хавийн газар орны баялгийг шинжиж цуглуулаад явах янзгүй удаад байж. Тэр нутгийн нэгэн номтой чадалтай ламын дургүй нь хүрч “муу шуналын тулам чамайг биетэй, майхантай чинь газар шороо, хад асга болгож хувиргана даа” гээд догшин уншлага уншаад яг шөнө дунд номын ид шид гүйцэх гэж байтал нөгөө хятад мэдээд санд мэнд зугтаж майханаа тэнд орхисноос майхан нь тэр янзаараа уул болсон гэдэг. Тэр цагаас хойг тэр уулыг Майхан хэмээн нэрлэх болжээ.

Мөн Давхар уулын домогт, Мандал сумын нутагт Бороо голын зүүн талд Давхар уул бий. Бороогийн саваас хол, ойрын хүмүүс алт хайж өрсөлдөж байсан цагт нэгэн их шуналтай хүн бусдыгаа устгаж өөрөө бүх алтны эзэн болох гэж ойролцоох нэгэн уулыг зааж энэ уулыг бүтнээр нь ховхлоод авчихвал доор нь их алт байгаа гэж баараггүй мэргэн хүн хэллээ гэж. Гэнэн хүмүүс үгэнд нь ороод өнөөх багахан уулыг өргөж аваад хажуугийнх нь уулан дээр давхарлаад тавьчихсан нь Давхар уул нэртэй болжээ. Харин доороос нь алт биш аварга могой өндийж иржээ. Бүх хүмүүс уул дамжаад явчихсан, ганцхан нөгөөх шунахай муу санаат хүн тэнд үлдсэн байсныг аварга могой ухасхийн залгичихсан гэдэг.

Оорцог

Айлаас ямагт зайдуу ганцаараа явдаг Оорцог Оролмаа гэдэг ганц бие бүсгүй өвөлжөөндөө дөхөж намаржаандаа буугаад байж, орой нохой шуугиулсаар нэгэн хүн иржээ. Оролмаа гарч нохой хорив. Морь тэрэгтэй данжаад:

Хай сайн байнуу?

Сайн, сайн байна уу

Ээний уулаа хээн? Гэж урагш заав.

Хэрхэнцэг

Ээний гоолий хээн?

Орхироо

Хай, хүүхэний нээлий хээн?

Оролмаа

Хай манай пүүсээ хаа байнаа?

Тийшээ гэж доод руу зааж, данжаад морио гуядаж шогшуулсаар Хэрхэнцэг уулыг тойроод ирж

Хай нохой холив оо гэхэд Оролмаа гарав.

Хай сайн байнуу?

Сайн байнаа, та сайн уу?

Энэ хэний уулаа?

Хэрх

Ээний уулаа хээн?

Хэрхэнцэг

Ээний голоо хээн?

Орхироо

Хай хүүхэний нээлий хээн?

Хай манай пүүсээ хаа байнаа?

Тийшээ

Хай, чүү гэж шогшуулсаар Хэрхэнцэг уулыг тойроод бас л ирж Хай нохой холивоо гэж хашхирахад Оролмаа гарсангүй.

Хай, баасий хээлхээ, хээлхэнцэг, баасий оолхилоо, баасий оолоомаа яамаалаа уучилаа байнаа гэж холдож голын захад бууж морио аргамжиж, гал түлж суутал үхэр мөөрөв. Гараа алгаараа хааж харвал цагаан толгойтой, цагаан үхэр эврээ сэжиж мөөрч байснаа чамайг иднэ гэж шороо цацалжээ. Данжаад босон харайж морь руу зааж хай, бугий тээлий моолии идэв аа гэж хашгираад дороо нам болжээ. Оролмаа тусгүй ажил хийсэн тул даруй ачаалж Орхироод намхан уулын өвөр бараадаж суурьшин суужээ. Тэр уулыг Оорцог гэж нэрлэсний учир ийм гэнэ.

Тайлбар: Нутгийн иргэдийн яриагаар тус нутагт амьдарч байсан хятад иргэдийн суурингийн үлдэгдэл нэлээд газарт байдаг ба Зуун мод руу ***Дээд байшин, дунд байшин, доод байшин гээд гурван хэсэг хужаа төв*** маягтай ногоо тарьдаг хашаатай нийлсэн 2, 3 хужаа худаг гаргасан бололтой суурингууд байдаг байна. Бид судалгааны далимаар хэдэн тийм суурин газрыг үзэж байршил зүйн зургийг хийсэн юм /х-92/. Нутгийн иргэн Найдангийн Пүрэвсүрэнгийн ярьсан нь:

Энд байсан хужаа нарын жаахан залуухан нь хүнтэй суугаад хөгшин болсон нь хүүхдүүдтэйгээ байж байгаад дууссан. Тэд нар төв рүү ороогүй. Хөх билүүтэд цоохор гэж нэг хятад байсан. Тэр хятадын байшингийн суур нь ч байдаг. Түүнийг алт нуусан газар руу хардаг байсан гэж нутгийнхан ярьдаг байсан. Нэг удаа Хүрлээ ахын хамт тэр хужаагийн алт нуусан гэх газрыг бүтэн өдөржин хайж байсан/инээв/. Би тэгээд хүүхдээ тэврээд дагаад хайж л явсан. 30-иад жилийн өмнөх яриа. Тэр хятадуудыг хоёр шуудай мөнгөө гээж байсан гэж хүмүүс ярьдаг. Тэгээд тэр дээр үеийн мөнгөө банкинд солиулаад хойтон хавар нь өнгөрсөн гэж ярьдаг. Тэр Хүрлээгийнх бол одоо мөнгөтэй баян сайхан л амьдарч байна. Тэднийх тийм баян айл байгаагүй.

Хужаагийн бөө толгой гэж байсан. Хужаа нарын тахидаг овоо. 3 байшингийн дээр бөө толгой гэж байсан. Шивэрийн 3 байшин гэж байгаа. Шивэртэд хужаа нар их байсан. Намайг мэдээ орох үед ээж хужаа нарт сүү өгч явуулдаг байсан. 1, 2л сүү өгч тэгж явуулахад хариуд нь хятадууд улаан будаа хуураад хуурсан будаа хийж өгч саванд нь хийж буцаадаг байсан. Бүдүүн Долгор гээд авгайтай нэг хятад байсан тэднийд их очиж сүү өгдөг байсан.

Хужаа нар шаврыг үнэхээр сайн зуурдаг, хоёр өдөр зуурдаг. Машин шар шавар буулгаад тэгээд тогоо шиг ус хийгээд шороо хийгээд нялбайлгана. Тэгээд эсгийгээр бүтээгээд өглөө тамхиа татаад сууж байдаг байсан хөгшин луухаанууд. Үдээс хойш гарч ирээд тэрийг таапуугаар татаад тэгээд цохиод тэрийг хажуу руу цэвэрхэн газар руу цохиулаад шидээд байна. Тэгэхээр далбайсан юм болно. Жаахан байж байгаад ус хийж шингээнэ. Эргүүлж

шумуулаад дахиад хонуулчихна. Тэгээд бүтээчихээд цайндаа явцгаана. Тэгээд үдээс хойш ирээд тэрийгээ хүрзээр зүсэж үзнэ. Гараараа имэрч үзээд гарт наалдахгүй байвал болоогүй гэсэн үг. Болоогүй бол эргүүлээд цохино. Дахиад бүтээж хаячихаад яваад өгнө. Цаг гаруй харж сууж байгаад дахиад имэрч үзнэ. Гарт наалдаад ирнэ. Тэр нь элдүүр нь ханаж байна гэсэн үг. Тэгээд тэрийгээ байшинд шавна. Тэгэхээр байшингийн дотор талаас дээвэр рүү шийдэхээр тап тап гээд таазанд наалдаад бөндийсөн юм болно. Тэрийг модон нэвигээр нэг л татна. Тэгж байсан юм. Одоо бид шаврыг дутуу хийж байна.

Мөн Энэ нутагт хоёр хятад амьдардаг байсан. Тухайн үед гуанз, хоолны газар, дэлгүүр зэргийг улс хураасан байдаг. Тэгэхэд нэг хятадынх нь гуанз хураагдаад зүгээр суудаг болсон. Тэр хятад ярихдаа би жилд 70000 төгрөгний орлогтой гуанзтай байсан. Одоо бол би юм хийхгүй гэж зүгээр сууж байгаа нь тэр гэнэ. Тэгээд хэзээ үхэхээ хүлээгээд тэгж суудаг байж.0 Харин нөгөө хятад нь амьжиргааны хэдэн цаас олох гээд явдаг. Нөгөө сууж байгаа хятад нь цонхоороо уул руу харж суудаг. Түүнийг хүмүүс нуусан алтаа харж сууж байсан нь тэр гэж хэлдэг. Тэр бол 60 хэдэн оны үеийн үйл явдал. Би буу үүрч анд явж байгаад тэдний очдог байсан. Тэр хоёр эндээ өнгөрсөн. Тэр ажил хийдэг хужаа нь өчнөөн олон нөхөөстэй паараасан өмдтэй тэрийгээ өвөл зунгүй өмсдөг байсан. Тэгэхэд 50т, 100тийн дэвсгэрт байсан үе. Тэрийг нөхөөсөн дээрээ тавиад оёчихсон байдаг гэдэг. Нөхөөстэй өмдтэй хужаа нь сүүлд нас барсан гэдэг.

Нутгийн хөгшчүүлийн ярьснаар бол тэр улаан Дамай гэдгийн эхийг Хятадууд алсан. Тиймээс хятадуудтай хонзонтой байсан гэж ярьдаг. Хятадууд түүний эхийг мориор дайрч алсан. Тэгээд улаан Дамай хятадад дургүй болсон гэдэг. Тэр улаан Дамайг ноён ууланд бүгж байгаад хойно уулнаас бууж ирэхэд нь хятадууд архи өгч хорлож алсан гэдэг. Тэгээд Бүдэн гэдэг луухаан би ганцаараа тэрийг алсан гэж шоронд орж хэсэг суугаад гарсан гэдэг. 1935 онд нас барсан юм уу даа.

Хужаа нар Түнхэлд бол зөндөө байсан. Буянтаас хунчир гэж өвс үү, чулуу юу алиныг мэдэхгүй. Тэрийг Хятадууд их авч байсан гэдэг. Буянт бол байхгүй юмгүй газар. Вансэмбэрүү цэцэг байлаа. Арц 2, 3 төрлөөрөө байсан. Бадаарын үндэс гэж байсан. Тэрийг ухуулаад 1кг-ийг 7 төгрөгөөр авч байсан. Түүгээр зүрхний эм хийдэг гэнэ. Үндсийг нь авдаг. Нэг хэсэг бадаарын үндэс авна гэж үйлдвэрийн ажилчдыг хүртэл аваачиж ухуулж байсан хэмээн хуучилсан бөгөөд хятад иргэдийн үлдэгдэл суурингаас түүвэрлэсэн зарим олдворыг дээжсийн зургийг тайланд хавсаргасан болно.

Сүхбаатарын хөшөө

Хиагтыг чөлөөлсний дараа ардын журамт цэрэг, улаан цэргийн ангиудын хамт Нийслэл хүрээг чөлөөлөхөөр явах замдаа 1921 оны 7 сарын эхээр Хараа голын сав Манхдайн адагт цагаантан Немчиновын отрядыг бут цохиод тэр шөнөө Хараа, Бороо голын бэлчирт хоногложээ. Маргааш өглөө нь Сүхбаатар аялах замынхаа алсын барааг өндөр газраас харахаар Ширхэнцэг уулын араас орой дээр нь гарч зогсож байсан нь бэлд байсан партизануудад тэнгэрт тасархай юм шиг сүрлэг харагдсан гэнэ. Тэгээд хожим уран барималч Чоймбол 1947 онд Сүхбаатарын морьт хөшөөг босгохоор зохиомжоо олон хувилбараар бодож

боловсруулж явахдаа хэдэн партизануудтай уулзаж энэ тухайгаа хэлэхэд партизанууд Сүхбаатар Ширхэнцэг уулын оройд морьтойгоо гараад наран ургах зүгт алсыг ширтэн зогсоход нь харагдсан сүрлэг дүр төрхийг ярьж өгснөөр Чоймбол гуай Сүхбаатарын хөшөөний доод хэсгийг Ширхэнцэгийн оройн хэлбэрийг дуурайлган хийсэн гэдэг.

ДӨРӨВ. УУЛ УУРХАЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛЭМЖ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй тийм их биш байгаа хэдий боловч ойрын хугацаанд алтны зарим томоохон уурхай ашиглалтад оруулах гэж байгаа. Энэхүү уурхайн үйл ажиллагаа хийгээд түүний зүгээс орон нутгийн иргэд, малчдад үзүүлэх нөхцлийн талаар нутгийн иргэд нэгдсэн нэг ойлголтод төдийлэн их хүрээгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. Биднийг хээрийн судалгаа хийж байх хугацаанд нутгийн иргэдтэй уулзаж, ярилцаж байхад тэдний үзэж байгаагаар уул уурхайн үйл ажиллагаа багагүй хэмжээгээр нөлөө үзүүлэх боломж тийм бага биш байна. Тэр дундаа Мандал сумын Хэрх багийн Хөх Билүүтэйн ам дагуух айлууд болон Ноён уулын урд ам, Балжийн амын айлуудад багагүй хэмжээгээр нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэдгийг ярьж байна. Нутгийн иргэдийн хувьд хамгийн гол анхаарал хандуулж, болгоомжилж байгаа нэг зүйл бол тухайн орчны малчдын малын бэлчээр болоод хэрэглээний усны асуудал гэж үзэж байна. Нутгийн иргэдийн ярьж байгаагаар "*Малын бэлчээргүй, зуслангүй л болно ш дээ. Манайх гэхээд л одоо байгаа Уртын амны зуслангаасаа баруун тийшээ даваад л өвөлждөг айл, хэрэв уурхайн үйл ажиллагаа явагдаж эхэлвэл тийм юм байхгүй болохоор болчихоод байгаа. Зарим нь бол эдийн засгаа сайжруулна, ухуулна л гэдэг юм билээ. Багш нар энэ тэр хүмүүс бол ухуулах нь зүйтэй л гэдэг юм билээ, дээд боловсролтой, сэхээтэн хүмүүс яагаад ч тэгэж ярьдаг юм мэдэхгүй л юм байна ш дээ. Яг уурхайтай холбоотой асуудал дээр Хараагийнхан бол нэг их ойшоохгүй, аж ахуйнхан л их юм ярьж, эсэргүүцдэг юм*" гэж Хэрх багийн малчин Даваасүрэн гуай ярьж байлаа. "*Уул уурхай гээд тэсэлгээ хийхээс хэцүү байна байх. Энд чинь бороогийн голд хийсэн уурхайн тэсэлгээ мэдэгддэг юм. Манай энд сонсогддог. Тэгээд нөгөө булш бунханд нөлөөлөх л байх. Тэр бол Хараад нөлөөлнө гэж бодож байна. Энэ хүмүүс нөлөөлөхгүй гээд байгаа. Тэр бол хэзээ нэгэн цагт нөлөөлнө. Тэд одоо нэг төмөр тороор хамгаалалт хийсэн л гэдэг. Тэр төмрийг нь нэг нь аваа л явчихна. Цаадхи руу хүн, амьтан орно доо. Уг нь төмрөөр сүрхий л хашаа барьсан байна лээ. Гэхдээ тэдний явлаа л гэвэл төмөр хашаа нь алга болж орхино. Түүнээс хойно бид цианиттай, хэдэн далантай л үлдэнэ байх. Центерра голдоос сум орон нутагт бол мөнгө өгсөн юм байна лээ"* гэж малчин Юмжирын Цолмон ярьж байлаа.

Тус сумын малчин, иргэдийн ярьж байгаагаар уурхайн үйл ажиллагаа явагдаж эхлэвэл түүнд ажиллах сонирхолтой хүмүүс тийм цөөн биш байгаа нь ажиглагдав. Үүнийг хүмүүс ярихдаа сум орон нутгийн эдийн засаг, өрх гэрийн эдийн засаг зэрэгт сайнаар нөлөө үзүүлэх боломжтой, залуучуудын ажилгүйдлийг бууруулах боломжтой гэж үзэж байв.

Судалгааны үр дүнгээс харахад уул уурхайн компани болоод орон нутгийн иргэд, удирдах байгууллагын хоорондын харилцаа тийм их биш байна гэж үзэхээр байлаа. Өөрөөр хэлбэл малчид, иргэд уул уурхайн компаний тухай ойлголт, түүнд өгөх үнэлэмж, дүгнэлт тэр хирээр бага байна гэж үзэж болохоор байв.

ТАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ

Хээрийн судалгааны үр дүнгээс дүгнэхэд Гацууртын ордын ойролцоох газар орон, тэдгээрийн ойр орчим оршин байгаа, уугуул иргэдийн уламжлалт хүндэтгэл, шүтлэг бишрэлийн объект болсон газар орон, уул овоодын талаарх уламжлалт мэдлэг ухааныг уугуул, үндсэн хэвээр нь хадгалан үлдээх боломжийг бид доор дурдсан байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Тухайн орон нутгийн уугуул иргэдийн амьдралын орчин, нутагшилд сөргөөр нөлөөлөхгүй байх (аливаа уугуул соёл, түүхэн мэдлэг уугуул хүнээр дамжигдан тээгдэж байдаг билээ).

Хүн амын хэт төвлөрлийг бий болгохгүй байх, түүнийг хийхдээ бүс нутаг, газарзүйн байршил зэргийг тооцож боловсруулах (тахилга шүтлэгэт, хорио цээрт газар орон руу аль болох нөлөөлөл бий болгохгүй байх).

Уул уурхайн болоод түүнд хамаарах дэд бүтцийн барилга, бүтээн байгуулалтыг тухайн бүс нутагт хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд дээр өгүүлсэн уул овоод, тахилгат газар оронд үзүүлэх нөлөөллийн хэмжээг аль болох бага хэмжээнд байлгах.

Энэ бол тухайн бүс нутаг дахь орон нутгийн уугуул иргэд, малчдын уламжлалт соёлын нэгэн том бүрэлдэхүүн хэсэг болох аман түүх, шүтлэг бишрэл, хорио цээрийн ёсыг хүндэтгэх, түүнийг хүлээн зөвшөөрөх, уугуул нийгмийг (native social) танин мэдэхэд томоохон түлхэц болох, аливаа соёлд хүндэтгэлтэй хандах илэрхийлэл болох юм.

Гацууртын орд түүний орчны бүсэд буй айл өрхийн аж ахуй, амьдралын хэв маяг, ёс заншил, газар усны хүндэтгэх сэтгэлгээ, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой тэдгээрийн санал бодол зэргийг тодорхойлоход чиглэгдсэн угсаатан зүйн судалгааг Хөх Билүүтийн ам, Уртын ам, Балжийн ам, Бага Буданчийн ам, Хэрх, Түнхэл тосгон, Бороо голын хөндийд хийж гүйцэтгэв. Энэ удаагийн угсаатны зүйн судалгаанаас доорх хэдэн дүгнэлтийг гаргав.

1. Гацууртын орд орчимд одоогийн байдлаар нутгийн уугуул иргэд тун цөөн үлдэж хоцорчээ. Ихэвчлэн хожим нүүдэлж ирсэн олон ястны өрх айлууд байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан нийт өрх айлын 90 орчим хувь гаднаас ирж суурьшжээ. Цаашид уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор энэ байдал улам ихсэх хандлага гарч тухайн бүс нутгийн газар усын нэр, үлгэр өөрчлөгдөх, мартагдах магадлал өндөр байна. Иймээс дээрх соёлын биет бус өвийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах талаар шат дараалалтай арга хэмжээ авах шаардлагатай байна.
2. Ноён уулын бүс нутаг нь монголчуудын эртний уламжлалт шүтлэг бишрэлийн төвүүдийн нэг бөгөөд түүнийг орон нутгийн шинж чанартайгаар тахилгын ёслол өнөө хир тасраагүй иржээ. Энэхүү тахил тайлгын ёслолыг цаашид уламжлалт ёс жаягийн дагуу үргэлжлүүлэн хийхэд орон нутаг, аж ахуйн нэгж, судалгааны байгууллагуудын олон талын оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй юм.
3. Гацууртын орд ашиглалтад ороход хөдөлмөрийн насны хүмүүсийн ажлын орон тооны хүлээлт их байгаагаас гадна гадна орон нутгийн хөгжилд хэр

хэрэгтэй талаас нь харж байна. Байгалийн нөхөн сэргээлтээ хийдэг, нийгмийн хариуцлагаа ухамсарладаг компани хийх, орон нутагт хор хохиролгүй, байгаль, түүхийн талын зүйлс хөндөгдөхгүй гэсэн баталгааг хүлээж байна. Үүний тулд, орон нутгийн иргэдэд энэ талын мэдээлэл их хэрэгтэй байгаа нь ажиглагдаж байна. Мэдээлэл байхгүйгээс буруу зөрүү ойлголтууд их болж айх болгоомжлох асуудал их гардаг бололтой юм. Иймд нутгийн ард түмнийг шаардлагатай мэдээллээр хангах хэрэгтэй гэж үзэж байна.

4. Гацуртын ордыг ашигласнаар тухайн бүс нутагт оршин сууж байгаа иргэд түүний дотроос малчин, тариаланч нарын амьдралын хэв маягт ямар нөлөө үзүүлэх талаар иргэдийн санал бодлыг харвал Бороогийн алтны уурхайгаас Гацуртын орд хүртлэх авто замаар хүдэр тээвэрлэх машины цуваа тодорхой хэмнэлээр үргэлжлэснээр тухайн ойр орчмын малын бэлчээр болон замын ойролцоо орших тариалангийн талбайд ямар нэгэн хэмжээгээр нөлөөлөх магадлалтай юм.